

Агуулга

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал	3
I. Нийгмийн үзүүлэлт	6
1. Ажиллах хүч	6
2. Ажилгүй иргэд	6
3. Нийгмийн даатгал, нийгмийн халамж	8
4. Эрүүл мэнд	9
5. Гэмт хэрэг	11
II. Макро эдийн засгийн үзүүлэлт	13
1. Үнэ	13
2. Мөнгө, зээл, үнэт цаас	18
3. Улсын нэгдсэн төсөв.....	22
4. Төлбөрийн тэнцэл	23
5. Гадаад худалдаа	24
III. Үйлдвэрлэл, үйлчилгээ	26
1. Мал аж ахуй	26
2. Аж үйлдвэр	28
3. Тээвэр	30
4. Даатгал	32
IV. Бусад	32
1. Цаг уур, агаарын бохирдолт	32
V. Хавсралт	34
VI. Жендерийн үзүүлэлтийн төлөв байдал	49
VII. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм	58

Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.



**Монгол Улсын нийгэм,
эдийн засгийн байдал**
(2012 оны эхний 5 сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сард 29914 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 2277 эх буюу 8.2 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 30064 болж, 2275 хүүхэд буюу 8.2 хувиар өслөө.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сард нялхсын эндэгдэл 492 болж, өмнөх оны мөн үеийнхээс 6 хүүхэд буюу 1.2 хувь, 1-5 хүртэлх насандаа 99 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 8 хүүхэд буюу 7.5 хувиар буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 5 дугаар сарын эцэст 58.2 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 мян.хүн буюу 35.9 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалд 2012 оны эхний 5 сард 555.0 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 358.0 мянга буюу 64.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагынх, 197.0 мянга буюу 35.5 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 66.5 мянга буюу 13.6 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 60.3 мянга буюу 20.2 хувь, төсөвт байгууллагынх 6.2 мянга буюу 3.3 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны эхний 5 сард 53.9 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 мян.хүн буюу 3.0 хувиар буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 5.6 сая төг буюу 41.6 хувиар нэмэгджээ.

“Хүний хөгжил” сангаас 2012 оны эхний 5 сард 308.4 тэрбум төгрөгийн хишиг хувь олгожээ. Энэ оны 5 дугаар сард давхардсан тоогоор 2.8 сая хүн 21.0 мян.төг, 132 мянган хүн 10.0 мян.төг, 2.8 мянган хүн 70.0 мян.төг бэлнээр авсан иргэд байна.

“Хүний хөгжил” сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт бэлнээр олгох 1.0 сая төгрөгийн хишиг хувиас 5 дугаар сард 63.7 тэрбум төгрөгийг 193.0 мян.хүнд олгожээ.

Халдварт өвчнөөр 2012 оны эхний 5 сард 20065 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 2952 хүн буюу 17.3 хувиар нэмэгдэхэд салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 568 хүн буюу 29.0 хувь, вирүст хепатитаар 1098 хүн буюу 23.0 хувь, цусан суулгаар 74 хүн буюу 11.8 хувь, сүрьеэгээр 95 хүн буюу 4.8 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 5 хүн буюу 0.2 хувиар буурсан хэдий ч гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 4398 хүн буюу 7.7 дахин, тэмбүүгээр 202 хүн буюу 11.3 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 91 хүн буюу 5.2 хувиар нэмэгдсэнээс голлон шалтгаалав.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сарын байдлаар 9613 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1066 хэргээр буюу 12.5 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (744), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (154), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (131), байгаль хамгаалах журмын эсрэг (54) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2012 оны эхний 5 сард 3539 хүн гэмтэж, 456 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 226 буюу 6.8 хувиар өсч, нас барсан хүний тоо 80 буюу 14.9 хувиар буурсан байна.

II.Макро эдийн засгийн үзүүлэлт

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 1.0 хувь, оны эхнээс 9.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 хувиар өслөө. Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнэ дүнгээрээ 1.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 2.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2012 оны 5 дугаар сарын эцэст 6729.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 366.7 тэрбум төг буюу 5.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1300.7 тэрбум төг буюу 24.0 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 5 дугаар сарын эцэст 782.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 74.0 тэрбум төг буюу 10.4



хувь, өмнөх оны мөн үеийнхээс 158.1 тэрбум төг буюу 25.3 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 5 дугаар сарын эцэст 6121.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 185.2 тэрбум төг буюу 3.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1874.4 тэрбум төг буюу 44.1 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 5 дугаар сарын эцэст 60.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 11.1 тэрбум төг буюу 15.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.7 тэрбум төг буюу 20.7 хувиар буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 5 дугаар сарын эцэст 315.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.9 тэрбум төг буюу 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 81.9 тэрбум төг буюу 20.6 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжаа 2012 оны 5 дугаар сард 23 өдөр явагдаж, 4.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 11.3 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны эхний 5 сард 1820.0 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2224.5 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 404.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Нэгдсэн төсвийн урсгал орлого 1813.9 тэрбум төг, урсгал зардал 1782.3 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 31.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 275.8 тэрбум төг буюу 20.4 хувиар нэмэгдэхэд дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 111.7 тэрбум төг буюу 22.7 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 82.0 тэрбум төг буюу 49.9 хувь, орлогын албан татварын орлого 36.3 тэрбум төг буюу 11.8 хувь, бусад татварын орлого 32.8 тэрбум төг буюу 12.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 11.2 тэрбум төг буюу 9.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 11.9 тэрбум төг буюу 6.8 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 14.1

тэрбум төг буюу 44.2 хувь, навигацын орлого 1.7 тэрбум буюу 8.9 хувиар буурсан хэдий ч бусад нэр заагдаагүй орлого 10.5 тэрбум төг буюу 73.2 хувь, газрын тосны орлого 7.4 тэрбум төг буюу 44.5 хувь, төсөвт газрын өөрийн орлого 4.9 тэрбум төг буюу 6.4 хувь, хүү, торгуулийн орлого 4.7 тэрбум төг буюу 31.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсөвт 2012 оны эхний 5 сард зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2224.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 742.5 тэрбум төг буюу 50.1 хувиар нэмэгдэхэд татаас ба шилжүүлгийн зардал 325.0 тэрбум төг буюу 46.7 хувь, хөрөнгийн зардал 204.6 тэрбум төг буюу 2.0 дахин, бараа, үйлчилгээний зардал 182.2 тэрбум төг буюу 33.6 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 18.0 тэрбум төг буюу 95.5 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 12.7 тэрбум төг буюу 49.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Хөрөнгийн зардалд 2012 оны эхний 5 сард 403.7 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 204.6 тэрбум төг буюу 2.0 дахин нэмэгджээ. Хөрөнгийн зардлын өсөлтөд дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 194.7 тэрбум төг буюу 99.4 хувь, гадаад эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 9.9 тэрбум төг буюу 4.0 дахин нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Монгол улс 2012 оны эхний 5 сард дэлхийн 121 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 4356.1 сая ам.долл, үүнээс экспорт 1708.1 сая ам.долл, импорт 2648.0 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 5 сард 939.9 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 400.4 сая ам.долл буюу 74.2 хувиар өсчээ. Үүнд импортын өсөлт экспортынхоос 16.8 пунктээр илүү өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 660.5 сая ам.долл буюу 17.9 хувь, үүний дотор импортын хэмжээ 530.4 сая ам.долл буюу 25.0 хувь, экспортын хэмжээ 130.1 сая ам.долл буюу 8.2 хувиар өсчээ.

Экспортын 98.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын



зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн, авто ба агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна.

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

2012 оны эхний 5 сард улсын хэмжээгээр 238.4 мян.толгой мал зүй бусаар хорогдож, өмнөх оны мөн үеийнхээс 198.7 мян.толгой буюу 45.5 хувиар буурсан байна. Зүй бусаар хорогдсон малыг төрлөөр авч үзвэл адуу 12.4 мянга, үхэр 22.2 мянга, тэмээ 469, хонь 94.4 мянга, ямаа 108.8 мянга байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 5 сард 834.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 69.9 тэрбум төг буюу 9.1 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, 35%-ийн металл агуулгад шилжүүлснээр, молибдений баяжмал, металл агуулгаараа, нүүрс, цайрын баяжмал, газрын тос, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.0-68.4 хувь, архи, нарийн боов, спирт, шар айраг, талх, амтат ус, ундаа, хивс, шингэн сүү, жүүс, металл бэлдэц, металл цувимал, цахилгаан утас, малын мах, шавардлагын зуурмаг, бетон дэр, шахмал түлш зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9 хувиас 5.4 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврээр 2012 оны эхний 5 сард 8336.4 мян.т ачаа тээж, давхардсан тоогоор 1594.5 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1327.5 мян.т буюу 18.9 хувь, зорчигчдын тоо 115.1 мян.хүн буюу 7.8 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөс төмөр замын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 5 сард 172.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 32.5 тэрбум төг буюу 23.2 хувиар өсчээ.

Агаарын тээврээр 2012 оны эхний 5 сард 1480.4 т ачаа тээж, давхардсан тоогоор 256.3 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 780.3 т буюу 2.1 дахин, зорчигчдын тоо 76.8 мян.хүн буюу 42.8 хувиар

өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 5 сард 59.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 12.7 тэрбум төг буюу 27.5 хувиар өслөө.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2012 оны 5 дугаар сард Дархан-Уул аймгийн Дархан суманд тохиолдож 51.9 мм-т хүрчээ. Энэ оны 5 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их температур 34.5 хэм, Хөвсгөл аймгийн Хатгал суманд хамгийн бага температур -13.2 хэм байлаа. Салхины хурд Увс аймгийн Улаангом суманд 34 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2012 оны 5 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол, Баруун дөрвөн зам орчимд тус бүр 26 удаа, Хархорин захын орчимд 7 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 1-р хороолол орчимд 3 удаа, 13-р хороолол орчимд 2 удаа, Баруун дөрвөн зам, 32-ын тойрог орчимд тус бүр 1 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин захын орчимд 31 удаа, 32-ын тойрог орчимд 29 удаа, 13-р хороолол орчимд 26 удаа, Баруун дөрвөн зам орчимд 22 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн зам орчимд 3 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Аюулт үзэгдэл, осол 2012 оны эхний 5 сард 1940 удаа гарсны улмаас 60 хүн амь насаа алдаж, 1.1 мянган толгой мал, амьтан хорогджээ. Энэ оны эхний 5 сард объектын түймэр 1722 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 15 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 13 удаа, бичил уурхай, нурангины осол 11 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага 10 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2012 оны эхний 5 сард 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 390-ээр нэмэгдэж, амь насаа алдсан хүний тоо 26-гаар буурав



I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Ажиллах хүч

Хүн амын эдийн засгийн идэвх

Ажиллах хүчний судалгааны 2012 оны 1 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1152.8 мянга байгаагийн 601.4 мянга буюу 52.2 хувь нь эрэгтэйчүүд, 551.4 мянга буюу 47.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын 590.8 мянга нь буюу 51.3 хувь нь хот суурин газарт, 562.0 мянга буюу 48.7 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) 2012 оны 1 дүгээр улиралд улсын хэмжээнд 64.6 хувь, хотод 57.7 хувь, хөдөөд 73.7 хувь байна.

2010 оны мөн үеийнхтэй харьцуулахад 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 41.8 мянга буюу 3.8 хувь, ажиллагчдын тоо 58.1 мянга буюу 6.0 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 74.5 мянга буюу 10.5 хувиар буурсан байна (Хүснэгт I.1).

15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 632.9 мянга буюу 35.4 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн амд багтаж байгаагийн 40.8 хувь нь эрэгтэйчүүд, 59.2 хувь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын 211.2 мянга буюу 33.4 хувь нь суралцагчид, 142.1 мянга буюу 22.5 хувь нь тэтгэвэрт, 83.5 мянга буюу 13.2 хувь нь гэрийн ажилтай, 48.4 мянга буюу 7.7 хувь нь хүүхэд асарсан, 43.2 мянга буюу 6.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна (Зураг I.1).


Судалгааны дүнгээр 2012 оны 1 дүгээр улиралд улсын хэмжээнд 118.8 мянган хүн ажил эрхлээгүй байгаагийн 63.6 мянга буюу 53.5 хувь нь эрэгтэйчүүд, 55.2 мянга буюу 46.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Судалгааны хугацаанд буюу 2012 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 10.3 хувь байна (Хүснэгт I. 2).

Хүснэгт-I.1

15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам, хүйсээр, жил бүрийн эхний улирлын байдлаар
(Ажиллах хүчний судалгааны дүнгээр)

Үзүүлэлт	2010 I-III	2011 I-III	2012 I-III
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, мян.хүн	1111.0	1121.9	1152.8
Эрэгтэй	582.7	594.3	601.4
Эмэгтэй	528.3	527.6	551.4
Ажиллагчид	975.9	1024.8	1034.0
Ажилгүй иргэд	135.1	97.1	118.8
Ажиллах хүчний оролцооны түвшин, %			
Улсын дундаж	61.1	59.4	64.6
Эрэгтэй	67.0	65.3	69.9
Эмэгтэй	55.7	54.0	59.6
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, мян.хүн	707.4	765.6	632.9
Эрэгтэй	287.1	315.5	258.5
Эмэгтэй	420.3	450.1	374.4

Зураг-I.1



Хүснэгт-I.2

15 ба түүнээс дээш насны хүн амын ажилгүйдэл, жил бүрийн эхний улирлын байдлаар (АХС-ны дүнгээр)

Үзүүлэлт	2010 I-III	2011 I-III	2012 I-III
Ажилгүй иргэдийн тоо, мян.хүн	135.1	97.1	118.8
Эрэгтэй	76.3	55.4	63.6
Эмэгтэй	58.8	41.7	55.2
Ажилгүйдлийн түвшин, %			
Улсын дундаж	12.2	8.7	10.3
Эрэгтэй	13.1	9.3	10.6
Эмэгтэй	11.1	7.9	10.0
Хот	15.6	9.3	11.7
Хөдөө	8.2	7.8	8.9

II.2 Бүртгэлтэй ажилгүй иргэн*

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 5 дугаар сарын эцэст 58.2 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 мян. хүнээр буюу 35.9 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 28.9 мянга буюу 49.7 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.9 пунктээр буурчээ. Аймаг, нийслэлийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст 2012 оны эхний 5 сард



ажилгүй 28.6 мян.иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 10.4 мянган ажилгүй иргэн ажилд зуучлагдан орж, 25.1 мян.иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ (Зураг I.2).

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.3 хувь нь магистр, доктор, 26.5 хувь нь дипломын болон бакалаврын, 5.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 6.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 41.1 хувь нь бүрэн дунд, 14.3 хувь нь суурь, 4.4 хувь нь бага боловсролтой, 0.9 хувь нь боловсролгүй иргэд байна (Зураг I.3). Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 35.8 мянга буюу 61.5 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаанбаатар хот болон Төв, Өмнөговь, Сэлэнгэ, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Орхон, Булган, Архангай аймагт улсын дунджаас 0.3-20.3 пунктээр их байна.

Ажлын шинэ байр *


Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэдээгээр 2012 оны эхний 5 сард 11987 хүн ажлын шинэ байранд ажилд орсны 5241 нь буюу 43.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал, 3.8 хувь нь боловсролын, 5.7 хувь нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний, 6.8 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 11.8 хувь нь барилгын, 12.7 хувь нь уул уурхай, олборлолтын, 13.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний, 15.8 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 16.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 13.8 хувь нь бусад салбарт ногдож байна (Зураг I.4).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн насны хувьд 2227 буюу 18.6 хувь нь 15-24 , 4484 буюу 37.4 хувь нь 25-34, 3007 буюу 25.1 хувь нь 35-44, 2118 буюу 17.7 хувь нь 45-59, 151 буюу 1.2 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна.(Зураг I.5).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 0.1 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 3.1 хувь нь менежер, 3.5 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 4.8 хувь нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 6.2 хувь


Зураг-I.2

ХХҮХ-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар




Зураг-I.3

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, хувиар, 2012 оны 5 дугаар сарын эцэст



Зураг-I.4

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд харьцуулсан хувиар, 2012 оны эхний 5 сард



* - Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээ



нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 8.3 хувь нь мэргэжилтэн, 15.7 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан, 18.6 хувь нь энгийн ажил мэргэжил, 19.1 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох үйлчилгээний ажилтан, 20.6 хувь нь худалдаа, үйлчилгээний мэргэжилтэй хүмүүс байна.

1.3 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 оны эхний 5 сард 399.9 тэрбум төг, зарлага 316.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 132.2 тэрбум төг буюу 49.4 хувь, зарлага 73.0 тэрбум төг буюу 30.0 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеийнхээс 132.2 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 100.2 тэрбум төг буюу 51.9 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 6.7 тэрбум төг буюу 47.6 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 3.9 тэрбум төг буюу 42.2 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 19.0 тэрбум төг буюу 44.6 хувь, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2.4 тэрбум төг буюу 27.8 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2012 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеийнхээс 73.0 тэрбум төгрөгөөр өсөхөд, тэтгэврийн даатгалын сангийн зарлага 53.3 тэрбум төг буюу 28.8 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 3.9 тэрбум төг буюу 34.2 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 14.9 тэрбум төг буюу 44.3 хувь, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 1.5 тэрбум төг буюу 16.5 хувиар өссөн нь нөлөөлөв. Харин ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 637.2 сая төг буюу 16.9 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2012 оны эхний 5 сард 232.1 тэрбум төг болсны 72.2 хувийг өндөр настны, 12.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 8.6 хувийг цэргийн, 6.5 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс цэргийн тэтгэвэр


Зураг-1.5

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, насны бүлгээр, хувиар, 2012 оны эхний 5 сард



Зураг-1.6

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, төрлөөр, 2012 оны эхний 5 сарын байдлаар, хувиар



61.5 хувь, өндөр настны тэтгэвэр 24.5 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр 32.0 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 22.0 хувиар өсчээ. (Зураг 1.6).

Нийгмийн даатгалд 2012 оны эхний 5 сард 555.0 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 358.0 мянга буюу 64.5 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 197.0 мянга буюу 35.5 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 66.5 мянга буюу 13.6 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 60.3 мянга буюу 20.2 хувь, төсөвт байгууллагынх 6.2 мянга буюу 3.3 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2012 оны эхний 5 сард 165.5 мян.хүнд 37.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд



өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 536 хүн буюу 0.3 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 11.3 тэрбум төг буюу 43.7 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 49.2 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 32.6 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 8.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 8.4 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 1.0 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөж буй иргэд байна. (Зураг 1.7).

Нийгмийн халамжийн сангаас 2012 оны эхний 5 сард олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 19.0 тэрбум төг буюу 51.3 хувийг халамжийн тэтгэвэрт, 11.2 тэрбум төг буюу 30.3 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 3.9 тэрбум төг буюу 10.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд, 2.5 тэрбум төг буюу 6.8 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 367.9 сая төг буюу 1.0 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна. (Зураг 1.8).

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны эхний 5 сард 53.9 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 мян.хүн буюу 3.0 хувиар буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 5.6 сая төг буюу 41.6 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 233.6 мян.хүн хамрагдсаны 11.0 хувь нь ахмад настан, 1.9 хувь нь алдар цолтой ахмад настан, 3.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 80.3 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 3.0 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.


“Хүний хөгжил” сангаас 2012 оны эхний 5 сард 308.4 тэрбум төгрөгийн хишиг хувь олгожээ. Энэ оны 5 дугаар сард давхардсан тоогоор 2.8 сая хүн 21.0 мян.төг, 132 мянган

1.4 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сард 29914 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 2277 эх буюу 8.2 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 30064 болж, 2275 хүүхэд буюу 8.2 хувиар өслөө (Зураг 1.9) Энэ оны 5 дугаар сард


Зураг-1.7

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2012 оны эхний 5 сарын байдлаар, хувиар



Зураг-1.8

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2012 оны эхний 5 сарын байдлаар, хувиар




хүн 10.0 мян. төг, 2.8 мянган хүн 70.0 мян. төг бэлнээр авсан байна.

Хүний хөгжил сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт бэлнээр олгох 1.0 сая төгрөгийн хишиг хувиас 5 дугаар сард 63.7 тэрбум төгрөгийг 193.0 мян.хүнд олгожээ.

Зураг-1.9

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар






6050 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 58 хүүхэд буюу 0.9 хувиар буурав.

Зураг-1.10

Улсын хэмжээгээр нялхсын эндэгдэл 492 болж, өмнөх оны мөн үеийнхээс 6 хүүхэд буюу 1.2 хувь, 1-5 хүртэлх насандаа 99 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 8 хүүхэд буюу 7.5 хувиар буурав. (Зураг 1.10). Энэ оны эхний 5 сард жирэмслэлт болон төрөлтийн улмаас 17 эх энджээ. Энэ оны 5 дугаар сард 4 эх эндсэн байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар




Нялхсын эндэгдэл 2012 оны 5 дугаар сард 107 болж, өмнөх оны мөн үеийнхээс 7 хүүхдээр, 1-5 хүртэлх насны 22 хүүхэд эндэж, 4 хүүхдээр өссөн байна.

Зураг-1.11

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2012 оны эхний 5 сард 16 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Хөвсгөл (35), Баян-Өлгий (28), Сүхбаатар (27), Ховд (24), Өвөрхангай (24) аймагт улсын дунджаас 8-19 хүүхдээр, Булган (23), Говь-Алтай (21), Төв (21), Завхан (20), Увс (19), Архангай (19), Өмнөговь (19), Баянхонгор (18), Дорноговь (17), Хэнтий (17) аймагт 1-7 хүүхдээр илүү байна.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны* хүүхдийн эндэгдэл энэ оны эхний 5 сард 20 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхдээр буурчээ. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2012 оны 5 дугаар сард 129 болж, өмнөх оны мөн үеийнхээс 11 хүүхдээр нэмэгдсэн байна.

185 хүн буюу 39.7 хувь, гонококкт халдвараар 51 хүн буюу 10.4 хувь, цусан суулгаар 13 хүн буюу 7.9 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 12 хүн буюу 2.7 хувиар буурсан хэдий ч гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 1782 хүн буюу 13.7 дахин, трихомониазаар өвчлөгчдийн тоо 83 хүн буюу 25.1 хувиар нэмэгдсэн нь нийт өвчлөгчдийн тоо өсөхөд нөлөөлөв.

Халдварт өвчнөөр 2012 оны эхний 5 сард 20065 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 2952 хүн буюу 17.3 хувиар нэмэгдэхэд салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 568 хүн буюу 29.0 хувь, вирүст хепатитаар 1098 хүн буюу 23.0 хувь, цусан суулгаар 74 хүн буюу 11.8 хувь, сүрьеэгээр 95 хүн буюу 4.8 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 5 хүн буюу 0.2 хувиар буурсан хэдий ч, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 4398 хүн буюу 7.7 дахин, тэмбүүгээр 202 хүн буюу 11.3 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 91 хүн буюу 5.2 хувиар нэмэгдсэнээс голлон шалтгаалав.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2012 оны эхний 5 сард улсын дунджаар 74 болж, өмнөх оны мөн үеийнхээс 13 хүнээр нэмэгдэв (Зураг 1.11).

Халдварт өвчнөөр 2012 оны 5 дугаар сард 4748 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 1263 хүн буюу 36.2 хувиар нэмэгджээ. Энэ хугацаанд вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 305 хүн буюу 45.3 хувь, салхин цэцгээр

Улаанбаатар хотод 2012 оны 5 дугаар сард ХДХВ/ДОХ-ын 1 тохиолдол илэрч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 109 болов.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сард 7328 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 131 хүн буюу 1.8 хувиар нэмэгдэв

Тайлбар: *Тав хүртэлх насны хүүхдэд 0-4 нас 365 хүртэл хоногтой хүүхдийг хамруулав.



(Зураг III.12). Эмнэлэгт нас барсан хүний тоо энэ оны эхний 5 сард 1789 болж, өмнөх оны мөн үеийнхээс 31 хүн буюу 1.8 хувиар өсөв. Энэ нь нийт нас баралтын 24.4 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо 2012 оны 5 дугаар сард 1465 болж, өмнөх оны мөн үеийнхээс 55 хүн буюу 3.6 хувиар буурав. Энэ оны эхний 5 сард 315.0 мян.хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 15090 хүн буюу 5.0 хувиар нэмэгджээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2012 оны 5 дугаар сард 60.5 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 1037 хүн буюу 1.7 хувиар буурав.

Хувийн эмнэлгүүд 2012 оны эхний 5 сард 564.3 мян.хүнд үйлчилж, 17.5 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 9.9 хувиар нэмэгдэж, төлбөрт үйлчилгээний хэмжээ 1.8 дахин өслөө.

I.4 Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сарын байдлаар 9613 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1066 хэргээр буюу 12.5 хувиар өсчээ (Зураг I.13). Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (744), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (154), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (131), байгаль хамгаалах журмын эсрэг (54) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 57.0 хувь нь нийслэлд, 41.8 хувь нь аймгуудад, 0.6 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.6 хувь нь бусад газарт 2012 оны эхний 5 сард бүртгэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 45.9 хувийг хүндэвтэр, 42.4 хувийг хөнгөн, 9.2 хувийг хүнд, 2.5 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс хөнгөн хэргийнх 2.4 пунктээр нэмэгдэж, хүндэвтэр хэргийнх 1.6 пункт, хүнд хэргийнх 0.6 пункт, онц хүнд хэргийнх 0.2 пунктээр буурсан байна (Зураг I.14).

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Завхан аймагт 64.9 хувь, Говь-Алтай аймагт 44.3 хувь, Өвөрхангай

Зураг-I.12


Нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



■ Нас барсан нийт хүний тоо ■ Эмнэлэгт нас барсан хүний тоо


Зураг-I.13

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Зураг-I.14

Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн ангиллаар, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар



аймагт 34.2 хувь, Сүхбаатар аймагт 25.0 хувь, Говьсүмбэр аймагт 20.4 хувь, Дорнод аймагт 19.7 хувь, Баян-Өлгий аймагт 17.8 хувь, Булган аймагт 17.6 хувь, Дундговь аймагт 10.8 хувь, Төв аймагт 10.7 хувь, Дархан-Уул аймагт 6.9 хувь, Баянхонгор аймагт 4.3 хувь, Орхон, Хэнтий аймагт тус бүр 4.2 хувь, Дорноговь аймагт 2.8 хувь, Сэлэнгэ аймагт 0.6 хувь, Улаанбаатар хотод




14.9 хувиар нэмэгдэж, харин Увс аймагт 10.7 хувь, Ховд аймагт 10.5 хувь, Хөвсгөл аймагт 7.3 хувь, Архангай аймагт 4.9 хувь, Өмнөговь аймагт 1.3 хувиар буурчээ.

Зураг-1.15

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 275 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 108 хэрэг буюу 64.7 хувиар нэмэгдсэн байна. Малын хулгайн 674 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 7.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 150 хэрэг буюу 28.6 хувиар өсчээ.

Сэжигтэн нь тодорхойгүй байсан 3466 хэргийн 1982 буюу 57.2 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 2.0 пунктээр нэмэгдэж, харин нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 3.0 пунктээр буурсан байна. (Зураг 1.15).



Зураг-1.16

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 2012 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеийнхээс 28.4 хувь, бүлэглэн үйлдсэн хэрэг 8.4 хувиар нэмэгдэж, хүүхэд оролцсон хэрэг 3.4 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 1.4 хувиар буурав.

18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд улсын дунджаар 2012 оны эхний 5 сард 51 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5 хэрэг буюу 10.9 хувиар нэмэгдэв.



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2012 оны эхний 5 сард 8573 болж, 570 буюу 6.6 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 1162 буюу 13.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 5.1 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр буурчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь 2012 оны эхний 5 сард 10.3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.1 пункт, малчдынх 9.9 хувь болж 2.6 пункт, төрийн бус байгууллагын ажиллагчдынх 1.8 хувь болж 0.5 пунктээр нэмэгдэж, харин ажилгүй иргэдийн эзлэх хувь 54.4 болж 3.4 пункт, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдынх 10.7 хувь болж 1.4 пункт, оюутан, сурагчдынх 7.3 хувь болж 0.5 пункт, төрийн албан хаагчдынх 4.3 хувь болж 0.4 пунктээр буурсан байна.

Энэ оны эхний 5 сард бүртгэгдсэн гэмт хэргийн 31.8 хувь нь гэр, орон сууцанд, 15.5 хувь нь гудамж, талбайд, 14.0 хувь нь олон нийтийн газарт, 8.1 хувь нь аж ахуйн нэгжид, 7.5 хувь нь авто замд, 2.2 хувь нь төрийн байгууллагад, 1.4 хувь нь төрийн бус байгууллагад, 1.4 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 18.1 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 3539 хүн гэмтэж, 456 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 226 буюу 6.8 хувиар өсч,




нас барсан хүний тоо 80 буюу 14.9 хувиар буурсан байна (Зураг I.13).

Зураг-I.13

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2012 оны эхний 5 сард 20.0 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 8.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 8326.2 сая төг буюу 71.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 4049.9 сая төг буюу 83.9 хувиар өссөн байна (Зураг I.14). Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ нэмэгдэхэд хувийн өмчийн байгууллагад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 3067.9 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 83.3 хувь буюу 16.7 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.


Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Зураг-I.14

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2012 оны эхний 5 сард 9215 болж, 614 буюу 6.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 3397 буюу 36.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөгөөр



Түүнчлэн гэмт хэргийн улмаас нийт 74 байгууллагад хохирол учирсны 34 нь төрийн, 14 нь төрийн бус, 26 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сард 51.8 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 6.0 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 947 буюу 1.8 хувиар буурч, баривчлагдсан хүний тоо 441 буюу 7.9 хувиар өссөн байна.

II.Макро эдийн засгийн үзүүлэлт

II.1 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 1.0

хувь, оны эхнээс 9.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 хувиар өслөө (Хүснэгт II.1). Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнс,

Хүснэгт-II.1

Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	хувь		
		2012 V / 2011 V	2012 V / 2011 XII	2012 V / 2012 IV
Ерөнхий индекс	100.0	115.4	109.2	101.0
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	124.6	121.8	101.3
Согтууруулах ундаа, тамхи	3.2	105.1	104.3	100.4
Хувцас, бөс бараа, гутал	16.1	117.1	106.8	100.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	111.6	100.9	102.4
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.7	108.2	104.3	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.0	104.2	100.2
Тээвэр	12.2	113.8	103.8	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	98.9	99.1	99.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	104.8	103.1	99.8
Боловсролын үйлчилгээ	4.7	109.9	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	123.5	118.0	102.7
Бусад бараа, үйлчилгээ	4.1	106.5	103.5	100.6



ундаа, усны бүлгийн барааны үнэ дүнгээрээ 1.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 2.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Согтууруулах ундаа, тамхины бүлгийн барааны үнэ дүнгээрээ 0.4 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.8 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.2 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.2 хувь, тээврийн бүлгийнх 0.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 2.7 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.6 хувь өсч, боловсролын бүлгийн үйлчилгээний үнэ дүнгээрээ тогтвортой, харин холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ, тариф дүнгээрээ 0.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.2 хувиар буурсан байна.

Хэрэглээний үнийн улсын индекс 2012 оны 5 дугаар сард оны эхнээс 9.2 хувь өссөний дотор хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнэ дүнгээрээ 21.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийнх 18.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 6.8 хувиар нэмэгджээ.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 5 дугаар сард оны эхнээс 4.3 хувиар өссөн бол 2012 оны 5 дугаар сард 9.2 хувь болж, өсөлт 4.9 пунктээр нэмэгджээ (Зураг II.1).


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас Өмнөговь аймагт 0.1 хувь, Дундговь аймагт 0.2 хувь, Говь-Алтай аймагт 0.9 хувиар буурч, бусад аймагт 0.1-2.6 хувиар өсчээ (Зураг II.2).

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас Говьсүмбэр (2.4%), Орхон (1.2%), Төв (0.8%), Говь-Алтай (0.7%) аймагт буурч, бусад аймагт 0.1-17.9 хувиар өсчээ. Баян-Өлгий (17.9%) аймагт хамгийн өндөр өсөлттэй байв.

Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ дүнгээрээ Говь-Алтай (1.7%), Говьсүмбэр (1.1%), Сүхбаатар (0.6%), Төв (0.4%) аймагт буурч, Хэнтий, Орхон, Дундговь, Архангай, Дорноговь, Баянхонгор, Булган, Сэлэнгэ, Ховд аймагт тогтвортой, бусад 8 аймагт 0.1-5.7 хувиар өссөн байлаа. Завхан (5.7%) аймагт хамгийн өндөр өсөлттэй байжээ.

Сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ Архангай (1.0%), Хэнтий (0.9%), Ховд (0.1%) аймагт өсч, Дорноговь,

Зураг-II.1



Зураг-II.2



Баян-Өлгий, Өмнөговь аймагт тогтвортой, бусад 15 аймагт 1.3-10.6 хувиар буурсан байна. Говь-Алтай (10.6%) аймагт хамгийн их бууралттай байв.

Төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ дүнгээрээ Говь-Алтай (8.2%), Дорнод (6.2%), Баян-Өлгий (4.5%), Говьсүмбэр (3.9%), Дундговь (1.1%), Өмнөговь (0.3%), Сүхбаатар (0.1), аймагт буурч, Завхан, Булган, Архангай аймагт тогтвортой, бусад 11 аймагт 0.1-18.7 хувиар өссөн байна. Өвөрхангай (18.7%) аймагт хамгийн өндөр өсөлттэй байлаа.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас Сэлэнгэ аймагт хамгийн их буюу 2.6 хувиар өсчээ. Тус аймагт үнэ өсөхөд хүнсний бүлгийн барааны үнэ дүнгээрээ 4.5 хувь, үүний дотор мах, махан бүтээгдэхүүний үнэ 10.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 7.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Говь-Алтай аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 0.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үнийн бууралтад хүнсний бүлгийн барааны үнэ дүнгээрээ 2.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 3.0 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.




Хэрэглээний үнийн индекс 2012 оны 5 дугаар сард оны эхнээс бүх аймагт 4.4-13.2 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 5 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 1.0 хувь, оны эхнээс 9.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 16.6 хувиар өслөө.


2012 оны 5 дугаар сард хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнэ дүнгээрээ 1.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 0.5 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.2 хувь, орон сууц, цахилгаан, түлшнийх 3.1 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.1 хувь, тээврийн бүлгийнх 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 3.4 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.5 хувь, Харин гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 0.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.4 хувиар буурч, боловсролын бүлгийн үйлчилгээний үнэ дүнгээрээ тогтвортой байв (Зураг II.3).

Зураг-II.3


Улаанбаатар хотын ХҮИ-ийн 2012 оны 5 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар



Улаанбаатар хотын ХҮИ-ийн 2012 оны 3 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар



Улаанбаатар хотын ХҮИ-ийн 2012 оны 4 дүгээр сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар





Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2012 оны 5 дугаар сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт, %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	1.2	Хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний үнэ 2.4 хувь, жимс, жимсгэнийх 3.9 хувь, төмс, хүнсний ногооных 1.4 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүнийх 1.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд дотоодын архи, шар айрагны үнэ 0.9-1.5 хувь, оргилуун дарсны үнэ 1.0 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд эрэгтэй бэлэн хувцасны үнэ 1.2 хувь, хүүхдийнх 0.1 хувь, бүх төрлийн гутлынх 0.5 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	3.1	Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн бараа, үйлчилгээний үнийн өсөлтөд орон сууц түрээслэх хөлс 19.5 хувь, орон сууцны засварын зарим материалын үнэ 1.2-6.7 хувь, 1 шуудай түлшний модны үнэ 2.5 хувь, нүүрснийх 3.0 хувиар өссөн нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	-0.8	Энэ бүлгийн үнийн бууралтад гэр ахуйн зарим цахилгаан барааны үнэ 1.6-11.4 хувиар буурсан нь нөлөөлөв.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд шүдэнд ломбо тавиулах үйлчилгээний хөлс 3.0 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.
Тээвэр	0.6	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд АИ-80 бензиний үнэ 3.5 хувь, задгай зогсоолын төлбөр 15.4 хувиар өссөн нь нөлөөлөв.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.5	Энэ бүлгийн үнийн бууралтад интернэт ашиглах хөлс 1.5 хувь, олон улсад картаар ярих тариф 8.3 хувиар хямдарсан нь нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-0.4	Энэ бүлгийн үнийн бууралтад LCD зурагтын үнэ 5.4 хувь, MP-4 хөгжим тоглуулагчийн үнэ 1.0 хувиар хямдарсан нь нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.4	Энэ бүлгийн үнийн өсөлт нь цайны газрын хоолны үнэ 7.4 хувиар нэмэгдсэнээс шалтгаалжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.5	Бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд ариун цэврийн цаасны үнэ 1.1 хувь, үсний шингэн савангийн үнэ 4.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим ноолуурын үнэ Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн Орхон, Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу судалгаагаар 2012 оны 5 дугаар сард үхрийн 35.0-40.0 мян.төг, Завхан, Өвөрхангай, Төв, 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Ховд, Архангай, Хөвсгөл аймагт хамгийн их буюу Дархан-Уул, Дундговь, Увс аймагт хамгийн 43.5-46.0 мян.төг байна.

бага буюу 15.0-23.0 мян.төг, Өвөрхангай, Төв, Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний Булган, Архангай аймаг, Улаанбаатар хотод дундаж үнэ Булган, Өвөрхангай, Баянхонгор хамгийн их буюу 32.0-40.0 мян.төг, адууны аймагт өмнөх сарынхаас 1.5-2.0 мян.төг буюу ширнийх Ховд, Баян-Өлгий, Архангай, 4.7-7.1 хувиар өсч, Архангай, Завхан, Дорнод, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Орхон, Орхон, Говьсүмбэр, Ховд, Төв, Дархан-Уул Дундговь аймагт хамгийн бага буюу 15.0-23.0 аймагт 3.0-10.0 мян.төг буюу 7.9-33.3 хувиар мян.төг, Хэнтий, Төв, Завхан аймагт хамгийн буурч, Сүхбаатар, Сэлэнгэ аймагт өмнөх их буюу 27.0-30.0 мян.төг, ямааны 1 кг цагаан сарын түвшинд байв.



Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ сарынхаас 1.0-8.0 мян.төг буюу 2.5-22.9 Баян-Өлгий, Булган, Завхан аймагт өмнөх хувиар өсч, Сүхбаатар, Хөвсгөл, Орхон, сарын түвшинд, бусад аймаг, Улаанбаатар Сэлэнгэ аймагт 6.5-10.0 мян.төг буюу 13.2-22.2 хувиар буурч, Говь-Алтай, Дундговь, хотод өмнөх сарынхаас 2.5-10.0 мян.төг буюу 10.0-33.3 хувиар буурав.

Ямааны 1 кг цагаан ноолуурын дундаж үнэ Ховд, Завхан, Баян-Өлгий аймагт өмнөх

Зураг-II.4


Ямааны 1 кг цагаан ноолуурын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 5 дугаар сард, мян.төг




Адууны 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 5 дугаар сард, мян.төг



Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 5 дугаар сард, мян.төг



Хонины ноостой нэхийний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 5 дугаар сард, мян.төг



Улаанбаатар хотод арилжаалагдсан барилгын гол нэрийн материалын дундаж үнэ

Улаанбаатар хотод 2012 оны 5 дугаар сард арилжаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 37 нэр төрлийн материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа.

Өмнөх оны мөн үеийнхээс эх орны үйлдвэрийн захалсан банзны үнэ 2012 оны 5 дугаар сард 5.0 мян.төг буюу 12.5 хувь, хуурай палкных 2.0 мян.төг буюу 6.7 хувиар буурч, харин улаан тоосгоны нэг ширхэгийн

үнэ 152 төг буюу 2.2 дахин, 50 кг-ын савлагаатай цементний үнэ 3.3 мян.төг буюу 56.5 хувь, хөнгөн бетоных 35.8 мян.төг буюу 34.1 хувь, вакуум цонхных (ховилгүй) 5.0 мян.төг буюу 6.3 хувь, ОХУ-д үйлдвэрлэсэн чулуутай хар цаасны үнэ 3.0 мян.төг буюу 17.6 хувиар өсчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн уян шүршүүрийн үнэ 10.0 мян.төг буюу 66.7 хувь, шаазан угаагуурынх 20.0 мян.төг буюу 33.3 хувь, крантных 10.0 мян.төг буюу 25.0 хувь, шахмал шалных 2.0 мян.төг буюу 18.2 хувь, төмөр хаалганых 22.0 мян.төг буюу 15.9 хувь, тосон будагных 300 төг буюу 15.0 хувь,



50 кг-ын савлагаатай цементнийх 1.0 мян.төг буюу 14.3 хувь, хар цаасных 1.0 мян.төг буюу 12.5 хувь, шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 11.1 хувь, өдрийн суурьгүй гэрлийнх 200 төг буюу 10.0 хувь, цонхны нөлөөгүй шилнийх 1.0 мян.төг буюу 8.3 хувь, эмульснийх (дотор) 500 төг буюу 7.7 хувиар өсч, харин дүүжин таазны үнэ 500 төг буюу 12.5 хувиар буурчээ. БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 500 төг буюу 10.0 хувиар өсөв.

Өмнөх сарынхаас 2012 оны 5 дугаар

сард эх орны үйлдвэрийн хөнгөн бетоны үнэ 22.8 мян.төг буюу 19.3 хувиар өсч, улаан тоосгоны нэг ширхэгийн үнэ 26 төг буюу 8.4 хувиар буурчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн тосон будагны үнэ 300 төг буюу 15.0 хувь, шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 14.3 хувь, өдрийн суурьгүй гэрлийнх 200 төг буюу 10.0 хувиар өслөө. Бусад материалын үнэ тогтвортой байлаа

II.2 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2012 оны 5 дугаар сарын эцэст 6729.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 366.7 тэрбум төг буюу 5.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1300.7 тэрбум төг буюу 24.0 хувиар өсчээ (Хүснэгт II.3).

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2012 оны 5 дугаар сарын эцэст 45.0 хувийг төгрөгийн хадгаламж, 17.8 хувийг гадаад валютын хадгаламж, 17.0 хувийг төгрөгийн харилцах, 11.3 хувийг гадаад валютын харилцах, 8.9 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг II.6). Мөнгөний нийлүүлэлтэд гадаад валютын хадгаламжийн эзлэх хувь өмнөх сарынхаас 2.1 пункт, банкнаас гадуурх мөнгөнийх 1.0 пунктээр өсч, харин төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь 1.9 пункт, гадаад валютын харилцахынх 1.0 пункт, төгрөгийн харилцахынх 0.2 пунктээр буурчээ.

Бага мөнгө 2012 оны 5 дугаар сарын эцэст 1741.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 145.6 тэрбум төг буюу 9.1 хувиар өсөв. Бага мөнгө өмнөх оны мөн үеийнхээс 318.6 тэрбум төг буюу 22.4 хувиар нэмэгдэхэд төгрөгийн харилцах 201.9 тэрбум төг буюу 21.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2012 оны 5 дугаар сарын эцэст 4224.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 243.9 тэрбум төг буюу 6.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 941.2 тэрбум төг буюу 28.7 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2012 оны 5 дугаар сарын эцэст 3024.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 42.6 тэрбум төг буюу 1.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 589.5 тэрбум төг буюу 24.2 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2012 оны 5 дугаар сарын эцэст 1200.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 201.3 тэрбум төг буюу 20.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 351.7 тэрбум төг буюу 41.4 хувиар өслөө (Хүснэгт II.5).


Хүснэгт-II.3

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2011 V	2012 IV	2012 V
Мөнгөний нийлүүлэлт M2	5 428.9	6 362.9	6 729.6
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	66.8	18.9	24.0
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.5	4.2	5.8
Нийт хадгаламж	3 283.7	3 981.0	4 224.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	63.1	23.5	28.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.9	6.3	6.1
Төгрөгийн хадгаламж	2 434.5	2 981.4	3 024.0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	72.5	26.2	24.2
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	3.0	0.0	1.4
Валютын хадгаламж	849.2	999.6	1 200.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	41.1	16.3	41.4
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 1.2	30.6	20.1

Зураг-II.5

Мөнгөний нийлүүлэлт (M2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)





Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 5 дугаар сарын эцэст 782.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 74.0 тэрбум төг буюу 10.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 158.1 тэрбум төг буюу 25.3 хувиар өсчээ.

Нөөц мөнгө (M0) 2012 оны 5 дугаар сарын эцэст 1825.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 121.4 тэрбум төг буюу 7.1 хувиар өслөө. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2012 оны 5 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 47.6 тэрбум төг буюу 4.8 хувиар өсч, 1044.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2012 оны 5 дугаар сарын эцэст 8923.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 325.1 тэрбум төг буюу 3.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2250.5 тэрбум төг буюу 33.7 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 5 дугаар сарын эцэст 6121.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 185.2 тэрбум төг буюу 3.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1874.4 тэрбум төг буюу 44.1 хувиар өсчээ (Хүснэгт II.4).


Зээлийн өрийн үлдэгдлийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2012 оны 5 дугаар сарын эцэст нийт зээлийн 3375.8 тэрбум төг буюу 55.1 хувь нь хувийн секторт, иргэдэд 2704.4 тэрбум төг буюу 44.2 хувь нь, улсын байгууллагад 16.3 тэрбум төг буюу 0.3 хувь нь, санхүүгийн бусад байгууллагад 16.2 тэрбум төг буюу 0.3 хувь нь, 8.5 тэрбум төг буюу 0.1 хувь нь бусад байгууллагад ногдож байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 5 дугаар сарын эцэст 315.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.9 тэрбум төг буюу 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 81.9 тэрбум төг буюу 20.6 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.2 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 4.2 пунктээр буурчээ (Хүснэгт II.4).

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 5 дугаар сарын эцэст 60.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 11.1 тэрбум төг буюу 15.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.7 тэрбум төг буюу 20.7 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 0.2 пункт, өмнөх


Зургаг-II.6

Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, жил бүрийн 5 дугаар сарын эцсийн байдлаар



Зургаг-II.7

Мөнгөний нийлүүлэлт (M2), бага мөнгө (M1) болон бараг мөнгөний өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)



Эх үүсвэр:* Монголбанкны статистикийн сарын бюллетень

Хүснэгт-II.4

Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2011 V	2012 IV	2012 V
Зээлийн өрийн үлдэгдэл	4 246.8	5 936.0	6 121.2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	48.9	49.4	44.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	6.9	2.7	3.1
Чанаргүй зээл	397.6	316.6	315.7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	-4.1	-17.0	-20.6
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	4.2	-1.1	-0.3
Хугацаа хэтэрсэн зээл	75.8	71.2	60.1
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	-40.6	-13.4	-20.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	-7.8	15.8	-15.6
Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь	9.4	5.3	5.2
Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	1.8	1.2	1.0



оны мөн үеийнхээс 0.8 пунктээр буурсан байна (Хүснэгт II.4).

Энэ оны 5 дугаар сарын эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 66.6 хувь нь ХААН банк, Голомт банк, Худалдаа, хөгжлийн банканд ногдож байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2012 оны 4 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 0.5 пункт, харин өмнөх оны мөн үеийнхээс 2.0 пунктээр өсч, жилийн хүү 18.4 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр буурч, жилийн хүү 12.4 хувь боллоо (Зураг II.9).

Гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны 5 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 38.4 сая ам.доллар, өмнөх оны мөн үеийнхээс 462.0 сая ам.доллараар нэмэгдэж, 2674.0 сая ам.долл болсон нь манай улсын импортын 21.9 долоо хоног буюу 5.5 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.10).


Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаа 2012 оны 5 дугаар сард 23 өдөр явагдаж, 4.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 11.3 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 565.6 сая төг буюу 13.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 тэрбум төг буюу 2.1 дахин өсчээ. Арилжсан үнэт цаасны тоо 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 3.1 сая ш буюу 21.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 9.1 сая ш буюу 5.3 дахин өслөө.


Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2012 оны 5 дугаар сард 20210.2 болж, өмнөх сарынхаас 107.3 нэгжээр буурчээ (Зураг II.11). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2012 оны 5 дугаар сард 1830.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 77.0 тэрбум төг буюу 4.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 27.0 тэрбум төг буюу 1.5 хувиар өслөө. (Зураг II.12).

“НАКО ТҮЛШ” хувьцаат компаний 7.7 сая ш хувьцаа 2012 оны 5 дугаар сард арилжигдсан нь хамгийн идэвхтэй арилжаалсан үнэт цаас байв.

Зураг-II.8




Зураг-II.9




Зураг-II.10

Гадаад валютын цэвэр албан нөөц, сарын эцэст, сая ам.долл




Зураг-II.11

ТОП-20 индекс, сарын дундаж, хувиар



Зураг-II.12

Зах зээлийн үнэлгээ, сарын эцэст, тэрбум төг



**Валютын ханш**

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 5 дугаар сард 1318.0 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 82.3 төг буюу 6.7 хувиар суларсан байна (Хүснэгт II.5). Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 1.5 хувиар чангарч, 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувиар суларчээ (Зураг II.13).

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 5 дугаар сард 1689.8 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 88.4 төг буюу 5.0 хувиар чангарчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 1.9 хувь, 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 2.2 хувиар чангарсан байна (Зураг II.14).

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 5 дугаар сард 208.4 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 18.1 төг буюу 9.5 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 1.4 хувиар чангарч, 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувиар суларчээ (Зураг II.15).


Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 5 дугаар сард 42.8 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 төг буюу 3.6 хувиар чангарчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 2.0 хувь, 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 3.8 хувиар чангарлаа (Зураг II.16).

Хүснэгт-II.5


Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Үзүүлэлт	2011 V	2012 IV	2012 V
Ам. Доллар	1 235.7	1 313.1	1 318.0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 10.9	7.6	6.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.3	- 1.5	0.4
Евро	1 778.2	1 728.4	1 689.8
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	1.5	- 2.0	- 5.0
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	0.8	- 1.9	- 2.2
Юань	190.3	208.2	208.4
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 6.3	11.4	9.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.8	- 1.4	0.1
Рубль	44.4	44.5	42.8
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 2.8	2.3	- 3.6
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	2.1	- 2.0	- 3.8


Зураг-II.13

Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг


Зураг-II.14

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Зураг-II.15

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Зураг-II.16

Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг



II.3 Улсын нэгдсэн төсөв

Зураг-II.17

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны эхний 5 сард 1820.0 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2224.5 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 404.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үеийнхээс улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 452.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлт 18.9 хувь, зарлагын өсөлт 50.1 хувь болж, зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 31.2 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ (Зураг II.17).

Нэгдсэн төсвийн урсгал орлого 1813.9 тэрбум төг, урсгал зардал 1782.3 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 31.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Өмнөх оны мөн үеийнхээс нэгдсэн төсвийн урсгал орлого 287.7 тэрбум төг, урсгал зардал 525.3 тэрбум төгрөгөөр өсчээ.


Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны 4 дүгээр сард 416.9 тэрбум төг байсан бол 2012 оны 5 дугаар сард 354.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 62.7 тэрбум төг буюу 15.1 хувиар буурлаа. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны 4 дүгээр сард 408.9 тэрбум төг байсан бол 2012 оны 5 дугаар сард 710.7 тэрбум төг болж өмнөх сарынхаас 301.8 тэрбум төг буюу 73.8 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2012 оны 4 дүгээр сард 8.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан бол 2012 оны 5 дугаар сард 356.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсөвт 2012 оны эхний 5 сард төвлөрсөн орлого ба тусламжийн нийт хэмжээ 1845.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 274.4 тэрбум төг буюу 17.5 хувиар нэмэгдлээ.

Өмнөх оны мөн үеийнхээс татварын нийт орлого 275.8 тэрбум төг буюу 20.4 хувиар нэмэгдэхэд дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 111.7 тэрбум төг буюу 22.7 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 82.0 тэрбум төг буюу 49.9 хувь, орлогын албан

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төг



татварын орлого 36.3 тэрбум төг буюу 11.8 хувь, бусад татварын орлого 32.8 тэрбум төг буюу 12.5 хувь, гадаад худалдааны татварын орлого 11.2 тэрбум төг буюу 9.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үеийнхээс татварын бус орлого 11.9 тэрбум төг буюу 6.8 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 14.1 тэрбум төг буюу 44.2 хувь, навигацын орлого 1.7 тэрбум төг буюу 8.9 хувиар буурсан хэдий ч бусад нэр заагдаагүй орлого 10.5 тэрбум төг буюу 73.2 хувь, газрын тосны орлого 7.4 тэрбум төг буюу 44.5 хувь, төсөвт газрын өөрийн орлого 4.9 тэрбум төг буюу 6.4 хувь, хүү, торгуулийн орлого 4.7 тэрбум төг буюу 31.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 88.3 хувийг татварын орлого, 10.0 хувийг татварын бус орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого, 1.4 хувийг тогтворжуулалтын сангийн орлого, 0.1



хувийг тусламжийн орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс татварын орлогын эзлэх хувь 2.2 пунктээр өсч, тогтворжуулалтын сангийнх 1.2 пункт, татварын бус орлогынх 1.0 пунктээр буурчээ (Хавсралт 5).

Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсөвт 2012 оны эхний 5 сард зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2224.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 742.5 тэрбум төг буюу 50.1 хувиар нэмэгдэхэд татаас ба шилжүүлгийн зардал 325.0 тэрбум төг буюу 46.7 хувь, хөрөнгийн зардал 204.6 тэрбум төг буюу 2.0 дахин, бараа, үйлчилгээний зардал 182.2 тэрбум төг буюу 33.6 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 18.0 тэрбум төг буюу 95.5 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 12.7 тэрбум төг буюу 49.1 хувиар өссөн нь

нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 80.1 хувь, хөрөнгийн зардал 18.2 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 1.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс урсгал зардлын эзлэх хувь 4.7 пунктээр буурч, хөрөнгийн зардлынх 4.7 пунктээр өсчээ (Хавсралт 5).

Хөрөнгийн зардал

Хөрөнгийн зардалд 2012 оны эхний 5 сард 403.7 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 204.6 тэрбум төг буюу 2.0 дахин нэмэгджээ. Энэ нь дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 194.7 тэрбум төг буюу 99.4 хувь, гадаад эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 9.9 тэрбум төг буюу 4.0 дахин өссөнөөс шалтгаалжээ.

II.4 Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2012 оны 1 дүгээр улиралд 358.8 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 321.0 сая ам.долл буюу 9.5 дахин өсчээ.

Урсгал данс


Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2012 оны 1 дүгээр улиралд 743.1 сая ам.долларын алдагдалтай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд 270.7 сая ам.долл буюу 57.3 хувиар өссөн. Үүнд бараа болон үйлчилгээний тэнцлийн алдагдал 706.8 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 294.3 сая ам.долл буюу 71.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Үйлчилгээний орлого 2012 оны 1 дүгээр улиралд 125.8 сая ам.долл, зарлага 450.4 сая ам.долл болж, үйлчилгээний тэнцэл 324.6 сая ам.долларын алдагдалтай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд 109.4 сая ам.долл буюу 50.8 хувиар нэмэгдсэн байна /Зураг II.18/. Үүнд тээврийн үйлчилгээний алдагдал 210.0 сая ам.долл, бусад үйлчилгээнийх 75.3 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс тээврийн үйлчилгээнийх 56.3 сая ам.долл буюу 36.6 хувиар, бусад үйлчилгээнийх 36.9 сая ам.долл буюу 96.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Орлогын дансны алдагдал 116.1 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс

Зураг-II.18

Бараа ба үйлчилгээний орлого, зарлага, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, сая ам.доллараар



алдагдал 7.4 сая ам.долл буюу 6.0 хувиар буурсан байна.

Харин урсгал шилжүүлэг 79.8 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 16.2 сая ам.долл буюу 25.5 хувиар нэмэгджээ. Ажиллагчдын мөнгөн гуйвуулга 2012 оны 1 дүгээр улиралд 29.2 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 сая ам.долл буюу 8.1 хувиар өсчээ.



Хөрөнгө ба санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 2012 оны 1 дүгээр улиралд 1288.3 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 742.8 сая ам.долл буюу 2.4 дахин өссөн байна.

Шууд хөрөнгө оруулалт нийт дүнгээрээ 2012 оны 1 дүгээр улиралд 900.0 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 152.6 сая ам.долл буюу 14.5 хувиар буурчээ. Харин санхүүгийн хөрөнгө оруулалт нийт дүнгээрээ 577.6 сая ам.долл болжээ.

II.5 Гадаад худалдаа


Монгол Улс 2012 оны эхний 5 сард дэлхийн 121 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 4356.1 сая ам.долл, үүнээс экспорт 1708.1 сая ам.долл, импорт 2648.0 сая ам.долларт хүрчээ (Зураг II.19). Өмнөх оны мөн үеийнхээс нийт бараа эргэлтийн хэмжээ 660.5 сая ам.долл буюу 17.9 хувь, үүний дотор импортын хэмжээ 530.4 сая ам.долл буюу 25.0 хувь, экспортын хэмжээ 130.1 сая ам.долл буюу 8.2 хувиар өсчээ.

Өмнөх оны эхний 5 сард гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.6 хувь нь БНХАУ-д, 13.7 хувь нь ОХУ-д, үлдсэн 29.7 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2012 оны эхний 5 сард нийт бараа эргэлтийн 51.8 хувь нь БНХАУ, 17.7 хувь нь ОХУ, 30.5 хувь нь бусад улсад ногдож байна. Өмнөх оны мөн үеийнхээс ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 4.0 пункт, бусад улсынх 0.8 пунктээр өсч, БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 4.8 пунктээр буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 5 сард 939.9 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 400.4 сая ам.долл буюу 74.2 хувиар өсчээ. Үүнд импортын өсөлт экспортынхоос 16.8 пунктээр илүү өссөн нь нөлөөлсөн байна.


Гадаад худалдааны тэнцэл 2011 оны 5 дугаар сард 118.1 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2012 оны 5 дугаар сард 151.7 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 33.6 сая ам.долл буюу 28.4 хувиар өсчээ.

Зураг-II.19



Зураг-II.20

Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2012 оны эхний 5 сарын байдлаар



Экспорт

Манай улс 2012 оны эхний 5 сард нийт 46 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 93.4 хувь, Канад улсад 2.0 хувь, ОХУ-д 1.6 хувь, Судан улсад 0.5 хувь, Итали, ХБНГУ, Швейцарь улсад тус бүр 0.4 хувь, Энэтхэг улсад 0.3 хувь, БНСУ болон Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсад тус бүр 0.2 хувь ногдож байгаа нь нийт экспортын 99.4 хувийг эзэлж байна (Зураг II.20).



Экспортын 98.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна (Хүснэгт II.6).

Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 130.1 сая ам.долл буюу 8.2 хувиар нэмэгдэхэд экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт 194.1 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Экспортын дүнд нүүрс 47.0 хувь, зэсийн баяжмал 19.9 хувь, төмрийн хүдэр 9.8 хувь, боловсруулаагүй газрын тос 7.4 хувь, цайрын хүдэр, баяжмал 2.8 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 2.3 хувь, жоншны хүдэр, баяжмал 1.9 хувь, бусад бүтээгдэхүүн 8.9 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт экспортод зэсийн баяжмалын эзлэх хувь 6.8 пункт, цайрын хүдэр, баяжмалынх 1.6 пункт, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 1.3 пункт, жоншны хүдэр, баяжмалынх 0.2 пунктээр буурч, нүүрснийх 12.3 пункт, боловсруулаагүй газрын тосных 1.8 пункт, төмрийн хүдрийнх 0.6 пунктээр өсчээ.

Импорт

Манай улс 2012 оны эхний 5 сард нийт 118 оронтой импортын худалдаа хийсний 28.1 хувийг ОХУ-тай, 24.9 хувийг БНХАУ-тай, 10.4 хувийг АНУ-тай, 7.7 хувийг Япон улстай, 6.6 хувийг БНСУ-тай, 3.6 хувийг ХБНГУ-тай хийсэн нь нийт дүнгийн 81.3 хувийг эзэлж байна (Зураг II.21). Импортын нийт хэмжээнд зарим орнуудын эзлэх хувийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ОХУ-ынх 5.7 пункт, АНУ-ынх 3.0 пункт, БНСУ-ынх 0.9 пункт, Япон улсынх 0.2 пунктээр өсч, БНХАУ-ынх 6.2 пункт, ХБНГУ-ынх 2.0 пунктээр буурчээ.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 530.4 сая ам.долл буюу 25.0 хувиар нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүний импорт 268.8 сая ам.долл, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 89.7 сая ам.долл, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийнх 34.3 сая ам.долл, хараа зүй, гэрэл, кино

Хүснэгт-II.6

Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар

	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Эрдэс бүтээгдэхүүн	79.1	85.1	90.0
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	8.1	7.3	4.7
Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	6.2	3.6	2.3
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	2.2	1.6	0.8
Авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	0.7	0.2	0.7
Бусад	3.7	2.2	1.5


Хүснэгт-II.7

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, мян.т

	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Нүүрс	4 699.1	6 037.5	7 398.0
Зэсийн баяжмал	239.5	236.2	231.1
Төмрийн хүдэр	872.9	1 938.8	2 387.4
Боловсруулаагүй газрын тос (мян.баррел)	901.8	888.2	1 261.7
Цайрын хүдэр, баяжмал	56.2	56.3	48.6
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	1.9	1.4	0.9

Зураг-II.21

Импортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2012 оны эхний 5 сарын байдлаар



зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсгийнх 22.0 сая ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 20.6 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 19.5 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Нийт импортод машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг 24.5 хувь, эрдэс бүтээгдэхүүн болон авто, агаарын замын



тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги тус бүр 22.8 хувь, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн 7.7 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 5.0 хувийг эзэлж, үлдсэн 17.2 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.22).

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2012 оны эхний 5 сард импортолсон гурил биет хэмжээгээр 4.4 мян.т, үнийн дүнгээр 4.3 сая ам.доллараар буурч, цахилгаан эрчим хүч биет хэмжээгээр 26.8 сая квт.ц, үнийн дүнгээр 2.1 сая ам.долл, суудлын автомашин биет хэмжээгээр 204 ш, үнийн дүнгээр 44.3 сая ам.долл, автобензин биет хэмжээгээр 31.8 мян.т, үнийн дүнгээр 76.6 сая ам.доллараар өсчээ (Зураг II.23).

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2012 оны эхний 5 сард 452.9 мян.т буюу 550.6 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 20.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 140.6 мян.т буюу 45.0 хувиар өссөн байна.

2012 оны эхний 5 сард газрын тосны бүтээгдэхүүнийг ОХУ, БНСУ, Беларусь улсаас; гурилыг ОХУ болон Казахстан улсаас; элсэн чихрийг Тайланд, ХБНГУ-аас; нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, ОХУ-аас; суудлын автомашиныг Япон, БНСУ, ХБНГУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас; ачааны автомашиныг АНУ, БНХАУ, БНСУ, Беларусь улсаас голлон авсан байна.

Импортолсон барааны 84.7 хувийг валютын төлбөртэй худалдаа, 13.0 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 2.2 хувийг тусламжийн бараа эзэлж байна.

III. Үйлдвэрлэл, үйлчилгээ


III.1 Мал аж ахуй

Улсын хэмжээнд 2011 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 15.7 сая хээлтэгч малын 12.9 сая хээлтэгч буюу 81.9 хувь нь 2012 оны эхний 5 сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 87.2 хувь, эм ямааны 83.3 хувь, үнээний 57.8 хувь, гүүний 50.6 хувь, ингэний 42.3 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.7 хувь буюу 12711.6 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1149.9 мянга буюу 9.9 хувиар их байна (Хавсралт 10).


Зураг-II.22

Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар



Зураг-II.23

Зарим барааны импорт, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, мян.ам.долл




Зураг-III.1

Төллөсөн хээлтэгчийн тоо, аймаг, нийслэлээр 2012 оны эхний 5 сард, мян.толгой





Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, жил бүрийн эхний 5 сард, мян.толгой



Унага бойжилт 97.8 хувь, тугал 98.3 хувь, ботго 98.5 хувь, хурга 98.9 хувь, ишиг 98.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2-1.4 пунктээр өсчээ (Зураг III.2, Хавсралт 11).

Зүй бусаар 2012 оны эхний 5 сард улсын хэмжээгээр 238.4 мян.толгой мал хорогдож, өмнөх оны мөн үеийнхээс 198.7 мян.толгой буюу 45.5 хувиар буурав. Зүй бусаар хорогдсон малыг төрлөөр авч үзвэл адуу 12.4 мянга, үхэр 22.2 мянга, тэмээ 469, хонь 94.4 мянга, ямаа 108.8 мянга байна (Зураг III.3). Нийт хорогдлын 39.6 хувийг хонь, 45.7 хувийг ямаа эзэлж байна.

2012 оны эхний 5 сард Архангай аймагт оны эхэнд тоологдсон малын 1.6 хувь буюу 48.8 мянга, Увс аймагт 1.4 хувь буюу 25.1 мянга, Говь-Алтай аймагт 1.5 хувь буюу 24.2 мянга, Хөвсгөл аймагт 0.7 хувь буюу 22.6 мянга, Ховд аймагт 0.7 хувь буюу 13.2 мянга, Булган аймагт 0.5 хувь буюу 12.4 мянга, Баянхонгор аймагт 0.5 хувь буюу 11.5 мянга, Сүхбаатар аймагт 0.6 хувь буюу 11.5 мянган мал хорогдлоо. Улсын хэмжээнд хорогдсон малын 71.1 хувийг эдгээр аймагт хорогдсон мал эзэлж байна (Зураг III.4).

Улсын хэмжээнд 2012 оны эхний 5 сард 13.4 мян.мал өвчнөөр хорогдсон нь өмнөх

Зүй бусаар хорогдсон том малын тоо, аймаг, нийслэлээр 2012 оны эхний 5 сард, мян.толгой




оны мөн үеийнхээс 0.7 мян.мал буюу 4.7 хувиар буурчээ.

Зураг-III.3



Зураг-III.4

Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр, жил бүрийн эхний 5 сард, мян.толгой




Газар тариалан

Улсын хэмжээнд 2012 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 284.9 мян.га талбайд тариалалт хийснээс үр тариа 257.3 мян.га-д, төмс 12.6 мян.га-д, хүнсний ногоо 4.6 мян.га-д, тэжээлийн ургамал 4.5 мян.га-д, техникийн ургамал 5.9 мян.га-д тариалсан байна.

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеийнхээс 4.5 мян.га буюу 1.6 хувиар бага байгаагийн дотор үр тарианых 12.4 мян.га буюу 4.6 хувиар буурч, харин төмснийх 1.7 мян.га буюу 15.5 хувь, хүнсний ногооных 640.9 га буюу 16.4 хувь, тэжээлийн ургамлынх 1.7 мян.га буюу 58.7 хувиар нэмэгдсэн байна (Зураг III.5).

Зураг-III.5

Тариалсан талбай, жил бүрийн 6 дугаар сарын 1-ний байдлаар, мян.га



Зураг-III.6

I.2 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 5 сард 834.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 69.9 тэрбум төг буюу 9.1 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр, молибдений баяжмал, металл агуулгаараа, нүүрс, цайрын баяжмал, газрын тос, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.0-68.4 хувь, архи, нарийн боов, спирт, шар айраг,

Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрчлөлт, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар, 2005 I-V=100%





талх, амтат ус, ундаа, хивс, шингэн сүү, жүүс, металл бэлдэц, металл цувимал, цахилгааны утас, малын мах, шавардлагын зуурмаг, бетон дэр, шахмал түлш зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9 хувиас 5.4 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Харин хайлуур жоншны баяжмал, алт зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.0-26.1 хувь, тамхи, хиаман төрлийн бүтээгдэхүүн, катодын зэс, зүсмэл материал, цемент, гурил, малын тэжээл, бетон зуурмаг, самнасан ноолуур зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.7-73.2 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 5 сард 2120.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 320.0 тэрбум төг буюу 17.8 хувиар өссөн бөгөөд үүний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 185.8 тэрбум төг буюу 14.8 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 105.4 тэрбум төг буюу 29.1 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 28.8 тэрбум төг буюу 15.9 хувиар тус тус өсчээ.


Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 5 сард оны үнээр 2322.8 тэрбум төг болж, үүний 1539.2 тэрбум төг буюу 66.3 хувийг гадаад зах зээлд борлуулжээ (Хавсралт 17).

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 60.2 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 30.8 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 9.0 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна (Зураг III.8). Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 5 сард 1398.4 тэрбум төг болж, 1260.3 тэрбум төг буюу 90.1 хувийг, боловсруулах аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 714.9 тэрбум төг болж, 278.9 тэрбум төг буюу 39.0 хувийг нь гадаад зах зээлд борлуулав.

Нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2012 оны эхний 5 сард 30.8 хувь болж, өмнөх оны мөн


Зураг-III.7

Түлш, эрчим хүчний гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрчлөлт, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар, 2005 I-V =100%



Зураг-III.8

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын бүтэц, дэд салбараар жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар



үеийнхээс 9.2 пунктээр нэмэгдэж, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 60.2 хувь болж, 8.6 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 9.0 хувь болж, 0.6 пунктээр буурлаа (Зураг III.8).


Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2012 оны 5 дугаар сарын эцэст 56945 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2446 хүн буюу 4.5 хувиар өсчээ. Ажиллагчдын тоо уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 579 хүн буюу 3.3 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 1686 хүн буюу 7.1 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 181 хүн буюу 1.4 хувиар өсчээ.



Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 2012 оны эхний 5 сард 15130.3 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 466.5 мян.төг буюу 3.2 хувиар өсчээ. Хөдөлмөрийн бүтээмж уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1156.1 мян.төг буюу 4.2 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 261.9 мян.төг буюу 3.6 хувиар өсч, харин боловсруулах аж үйлдвэрийн салбарт 159.5 мян.төг буюу 1.6 хувиар буурлаа.

Зураг-III.9а

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, мян.хүн



Зураг-III.9б

III.3.Тээвэр.

Төмөр замын тээврээр 2012 оны эхний 5 сард 8336.4 мян.т ачаа тээж, давхардсан тоогоор 1594.5 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1327.5 мян.т буюу 18.9 хувь, зорчигчдын тоо 115.1 мян.хүн буюу 7.8 хувиар өсчээ (Зураг III.9.а, III.9.б).


Төмөр замаар тээсэн нийт ачааны хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд дамжин өнгөрсөн ачааны хэмжээ 184.1 мян.т буюу 21.9 хувиар буурсан хэдий ч дотоодод тээвэрлэсэн ачаа 463.6 мян.т буюу 13.6 хувь, экспортын ачаа 789.4 мян.т буюу 37.3 хувь, импортын ачаа 258.6 мян.т буюу 39.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2012 оны 5 дугаар сард 1692.7 мян.т болж, өмнөх сарынхаас 5.5 мян.т буюу 0.3 хувиар буурч, зорчигчдын тоо 358.0 мян.хүн болж, 36.4 мян.хүн буюу 11.3 хувь, тээврийн орлого 38.6 тэрбум төг болж, 5.3 тэрбум төг буюу 15.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 203.5 мян.т буюу 13.7 хувь, зорчигчдын тоо 33.4 мян.хүн буюу 10.3 хувь, орлого 5.3 тэрбум төг буюу 15.8 хувиар тус тус нэмэгджээ (Зураг III.10.а, III.10.б).

Төмөр замын нийт ачаа тээвэрлэлтэд экспортын ачаа 34.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 4.7 пунктээр нэмэгдэхэд төмрийн хүдрийн тээвэрлэлт 660.3 мян.т буюу 41.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин төмөр замаар дотоодод тээвэрлэсэн ачаа нийт ачаа тээвэрлэлтийн 46.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 пунктээр буурсан байна.


Төмөр замын тээврийн салбарын орлого

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, мян.т




Зураг-III.10а

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мян.хүн



Зураг-III.10б

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мян.т





2012 оны эхний 5 сард 172.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 32.5 тэрбум төг буюу 23.2 хувиар өсчээ (Хүснэгт III.1).

Хүснэгт-III.1

Төмөр замын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар

Хугацаа, сараар	Тээврийн орлого, сая төг	Зорчигчдын тоо, мян.хүн	Тээсэн ачаа, мян.т
2010 I	19 860.5	257.9	1 277.8
II	18 766.2	294.5	1 169.5
III	21 037.8	248.3	1 198.9
IV	21 538.6	259.7	1 222.3
V	24 687.0	301.1	1 268.5
2010 I-V	105 890.2	1 361.6	6 137.0
2011 I	24 937.1	293.0	1 345.0
II	21 280.4	279.7	1 244.0
III	27 989.6	281.1	1 436.8
IV	32 225.5	301.1	1 494.0
V	33 386.3	324.6	1 489.1
2011 I-V	139 818.8	1 479.4	7 009.0
2012 I	32 900.5	293.7	1 733.8
II	35 161.1	316.2	1 529.2
III	32 191.4	305.0	1 682.6
IV	33 370.1	321.6	1 698.2
V	38 648.1	358.0	1 692.7
2012 I-V	172 271.1	1 594.5	8 336.4
2012 I-V 2011 I-V %	123.2	107.8	118.9
2012 V 2011 V %	115.8	110.3	113.7
2012 V 2012 IV %	115.8	111.3	99.7


Агаарын тээврээр 2012 оны эхний 5 сард 1480.4 т ачаа тээж, давхардсан тоогоор 256.3 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 780.3 т буюу 2.1 дахин, зорчигчдын тоо 76.8 мян.хүн буюу 42.8 хувиар өсчээ (Зураг III.11.а, III.11.б).

Агаарын тээврээр тээсэн ачаа 2012 оны 5 дугаар сард 300.5 т болж өмнөх сарынхаас 2.4 т буюу 0.8 хувь, орлого 12.4 тэрбум төг болж, 484.6 сая төг буюу 3.7 хувиар буурч, зорчигчдын тоо 55.6 мян.хүн болж, 2.0 мян. хүн буюу 3.8 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 157.8 т буюу 2.1 дахин, орлого 2.2 тэрбум төг буюу 21.7 хувь, зорчигчдын тоо 14.1 мян.хүн буюу 34.1 хувиар тус тус өссөн байна (Зураг III.12.а, III.12.б).

Агаарын тээврээр 2012 оны эхний 5 сард дотоодод зорчсон зорчигчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 42.5 мян.хүн буюу 70.8 хувь, олон улсад зорчсон зорчигчдын тоо 34.3 мян. хүн буюу 28.7 хувиар өсчээ.


Зураг-III.11а

Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, мян.хүн




Зураг-III.11б

Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, т




Зураг-III.12а

Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мян.хүн



Зураг-III.12 б

Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, т





Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 5 сард 59.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 12.7 тэрбум төг буюу 27.5 хувиар нэмэгдэв (Хүснэгт III.2).

III.4 Даатгал

Улсын хэмжээнд 2012 оны эхний улиралд 18 аж ахуйн нэгж, байгууллага даатгалын үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгалын хураамжийн орлого 17.7 тэрбум төг болж, даатгалын нөхөн төлбөрт 2.9 тэрбум төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс даатгалын хураамжийн орлого 8.7 тэрбум төг буюу 97.5 хувь, даатгалын нөхөн төлбөр 887.6 сая төг буюу 43.3 хувиар нэмэгджээ.

Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 8.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд эд хөрөнгийн даатгалынх 5.7 тэрбум төг буюу 2.1 дахин, хариуцлагын даатгалынх 2.0 тэрбум төг буюу 80.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 887.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд эд хөрөнгийн даатгалынх 477.0 сая төг буюу 36.5 хувь, санхүүгийн даатгалынх 176.4 сая төг буюу 2.5 дахин, хариуцлагын даатгалынх 81.0 сая төг буюу 20.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Даатгалын байгууллагад 2012 оны эхний улиралд давхардсан тоогоор 243.3 мян. даатгуулагч даатгуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 142.3 мян. даатгуулагч буюу 36.9 хувиар буурахад даатгуулсан иргэдийн

Агаарын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар

Хугацаа, сараар	Тээврийн орлого, сая төг	Зорчигчдын тоо, мян.хүн	Тээсэн ачаа, т	
2010 I	6 759.1	24.1	138.5	
II	6 096.3	19.8	102.1	
III	7 206.7	24.2	104.1	
IV	6 648.5	22.1	96.4	
V	10 295.7	26.5	108.6	
2010 I-IV	37 006.3	116.7	549.7	
2011 I	9 021.4	36.5	128.6	
II	9 021.2	29.2	123.5	
III	8 204.8	35.0	152.1	
IV	9 825.9	37.3	153.1	
V	10 220.4	41.5	142.8	
2011 I-IV	46 293.7	179.5	700.1	
2012 I	11 564.5	46.2	302.3	
II	10 517.8	47.9	251.4	
III	11 558.5	53.0	323.2	
IV	12 925.8	53.6	302.9	
V	12 441.2	55.6	300.5	
2012 I-IV	59 007.8	256.3	1 480.4	
2012 I-V	%	127.5	142.8	211.5
2011 I-V	%	121.7	134.1	210.5
2012 V	%	96.3	103.8	99.2
2011 V	%			
2012 IV	%			

тоо 148.4 мян буюу 38.8 хувиар буурсан нь нөлөөлжээ. Харин даатгуулагч хуулийн этгээдийн тоо 2010 оны эхний улиралд 1771, 2011 оны эхний улиралд 3467, 2012 оны эхний улиралд 9552 болж жилээс жилд нэмэгдэж байгаа нь даатгалын хураамжийн орлого өсөхөд нөлөөлж байна.

Даатгуулагчийн тоо, даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, даатгалын төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Даатгалын хэлбэр	Даатгуулагчийн тоо		2012 I-III, % 2011 I-III	Даатгалын хураамжийн орлого		2012 I-III, % 2011 I-III	Даатгалын нөхөн төлбөр		2012 I-III, % 2011 I-III
	2011 I-III	2012 I-III		2011 I-III	2012 I-III		2011 I-III	2012 I-III	
Амь нас, эрүүл мэндийн даатгал (арилжааны)	332 445	146 083	43.9	890.7	1 552.1	174.3	217.7	370.9	170.4
Эд хөрөнгийн даатгал	22 159	48 670	219.6	5 322.9	11 046.0	207.5	1 307.9	1 784.9	136.5
Хариуцлагын даатгал	30 262	48 247	159.4	2 490.5	4 488.8	180.2	405.4	486.4	120.0
Санхүүгийн даатгал	735	311	42.3	242.8	581.6	239.5	118.0	294.4	249.5
Бүгд	385 601	243 311	63.1	8 946.9	17 668.4	197.5	2 049.0	2 936.6	143.3

IV. Бусад

IV.1 Цаг уур, агаарын бохирдол

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2012 оны 5 дугаар сард Дархан-Уул аймгийн Дархан суманд

тохиолдож 51.9 мм-т хүрчээ. Энэ оны 5 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их температур 34.5 хэм, Хөвсгөл аймгийн Хатгал суманд хамгийн бага температур -13.2 хэм байлаа. Салхины хурд



Увс аймгийн Улаангом суманд 34 м/с хүрчээ.

Аймгийн төв, нийслэлд агаарын дундаж хэм 2012 оны 5 дугаар сард олон жилийн дунджаас 1.5 хэм хүйтэн, өмнөх оны мөн үеийнхээс 2.3 хэмээр дулаан байлаа.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2012 оны 5 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол, Баруун дөрвөн замын орчимд тус бүр 26 удаа, Хархорин захын орчимд 7 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 1-р хороолол орчимд 3 удаа, 13-р хороолол орчимд 2 удаа, Баруун дөрвөн зам, 32-ын тойрог орчимд тус бүр 1 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин захын орчимд 31 удаа, 32-ын тойрог орчимд 29 удаа, 13-р хороолол орчимд 26 удаа, Баруун дөрвөн замын орчимд 22 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 3 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс тус тус давсан байна (Зураг 1;2).

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2012 оны эхний 5 сард 1940 удаа гарсны улмаас 60 хүн амь насаа алдаж, 1.1 мянган толгой мал, амьтан хорогджээ. Энэ оны эхний 5 сард объектын түймэр 1722 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 15 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 13 удаа, бичил уурхай, нурангины осол 11 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага 10 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 4.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Объектын түймрээр 31 хүн, бичил уурхай, нурангины ослоор 14 хүн, гол нуурын усанд унаж осолдсон ослоор 9 хүн, ой, хээрийн түймрээр 4 хүн, сум галт хэрэгслийн ослоор 1 хүн, барилгын ослоор 1 хүн амь насаа алджээ.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 390-ээр нэмэгдэж, амь насаа алдсан хүний тоо 26-гаар буурав.

Хорогдсон мал, амьтдын тоо 2012 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеийнхээс 163.4 мянган толгойгоор бага байна (Хүснэгт IV.1).

Зураг-IV.1



Зураг-IV.2



Хүснэгт-IV.1

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний 5 сарын байдлаар*

Үзүүлэлт	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2012 I-V / 2011 I-V %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	1 342	1 550	1 940	125.2
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	98	86	60	69.8
Шатсан гэр, орон сууцны тоо	761	722	1 027	142.2
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, мян.тол	8 144.8	164.5	1.1	0.7
Объектын түймрийн тоо	1 168	1 352	1 722	127.4
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг	437.7	1.9	4.9	254.6

Тайлбар: *-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

С.МЭНДСАЙХАН



Хавсралт 1

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, бус, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар,

Аймаг, нийслэл	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо		Орон нутгийн төсвийн нийт орлого, нийт зарлагын харьцаа, хувиар		Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо		Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо			
	2010 I-V	2011 I-V	2010 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V	
ДҮН	38 701	42 797	58 159	160.9	176.3	8 326*	9 613*	15 286	17 113	20 065
Баруун бүс	7 774	8 480	8 562	104.0	113.5	646	710	1 459	1 416	1 351
БӨ	1 291	1 352	1 980	101.2	112.3	169	192	301	221	147
ГО	905	852	948	99.5	141.8	77	88	212	260	205
ЗА	2 278	2 781	1 978	107.8	97.7	84	97	212	328	279
УВ	1 922	1 059	921	127.9	124.0	169	159	425	360	262
ХО	1 378	2 436	2 735	82.4	95.0	147	143	309	247	458
Хангайн бүс	13 278	13 580	13 972	129.3	92.7	1 037	1 113	2 564	3 841	2 821
АР	1 896	2 181	2 164	133.1	124.0	186	174	195	485	375
БХ	3 104	2 162	1 946	117.6	127.7	170	162	678	983	568
БУ	907	1 143	833	105.0	135.2	102	108	351	427	470
ОР	2 254	1 916	2 403	147.9	76.3	240	212	285	395	387
ӨВ	2 772	3 759	3 481	114.3	108.0	151	202	271	696	494
ХӨ	2 345	2 419	3 145	120.9	112.2	188	246	770	855	527
Төвийн бүс	6 740	7 011	8 933	190.3	178.0	1 369	1 384	1 834	2 788	2 323
ГС	137	240	286	79.8	116.3	56	54	87	146	69
ДА	1 711	2 088	2 498	127.4	121.5	268	276	408	435	526
ДО	734	734	785	160.3	136.9	251	250	439	568	463
ДУ	895	1 010	950	125.7	175.6	88	93	108	215	222
ӨМ	501	542	1 093	249.6	251.4	138	150	112	544	233
СЭ	1 238	1 102	1 679	90.7	85.2	323	309	432	505	395
ТӨ	1 524	1 295	1 642	131.0	100.9	245	252	248	375	415
Зүүн бүс	3 185	3 099	5 252	119.3	116.7	541	584	1 406	1 441	1 714
ДД	964	846	2 254	134.6	132.8	222	223	752	693	999
СҮ	1 236	1 164	1 602	112.0	122.5	72	76	219	238	303
ХЭ	985	1 089	1 396	114.7	99.1	247	285	435	510	412
Улаанбаатар	7 724	10 627	21 440	117.7	271.4	4 639	4 773	8 023	7 627	11 856

* - Төмөр замын цагдаагийн хэлтэс, Иргэний агаарын тээврийн цагдаагийн тасагт бүртгэгдсэн болон Монгол Улсын иргэдийн хилийн чанадад үйлдсэн хэргүүдийг хамруулав.

**ХАМГИЙН ӨНДӨР, ХАМГИЙН БАГА ҮЗҮҮЛЭЛТТЭЙ АЙМАГ, НИЙСЛЭЛ**

	Хэмжих нэгж	Улсын дундаж	2012 оны эхний 5 сар			
			Хамгийн их	Хамгийн бага		
1000 хүнд ногдох төрөлт	0/00*	11.0	ХО	12.6	ТӨ	5.1
			ГС	12.4	БУ	7.2
			БӨ	12.2	СЭ	7.9
1000 хүнд ногдох нас баралт	0/00*	2.7	ДД	3.4	ӨМ	2.0
			ХӨ	3.3	БӨ,ТӨ	2.1
			ДА	3.0	ХО,ДО,СЭ,СҮ	2.4
Нялхсын нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд)	0/00*	16	ХӨ	35	СЭ	5
			БӨ	28	ГС	6
			СҮ	27	ДА	8
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0/000**	74	ДД	142	БӨ	17
			УБ	98	УВ	36
			БУ	87	ӨМ	37
Төрсөн 100 000 эхэд ногдох эхийн эндэгдэл	0/0000	53	ЗА	310	Бусад аймаг	0
			ТӨ	230	УБ	48
			СҮ	190	ДА	92
			СЭ	129	ӨВ	94
			ДД	123	БӨ	95
Орон нутгийн төсвийн нийт орлого, нийт зарлагын харьцаа зарлага=100	%	176.3	УБ	271.4	ОР	76.3
			ӨМ	251.4	СЭ	85.2
			ДУ	175.6	ХО	95.0

*-промилль

**- продицимилль



Хавсралт № 3

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

жил бүрийн 5 дугаар сарын байдлаар

	ХҮИ, %		Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, төг															
	2012.V	2012.V	I зэргийн гурил, кг				Хонины мах, кг				Үхрийн мах, кг				Цагаан будаа, кг			
	2012.IV	2011.XII	2010.V	2011.V	2012.V	2010.V	2011.V	2012.V	2010.V	2011.V	2012.V	2010.V	2011.V	2012.V	2010.V	2011.V	2012.V	
Баруун бүс																		
БӨ	101.3	107.8	390	560	580	4 000	4 000	6 500	6 500	4 000	3 900	4 000	6 500	6 500	1 600	1 600	1 700	1 700
ГО	99.1	107.8	600	900	900	6 000	3 900	5 800	5 800	6 000	4 000	6 000	6 500	6 500	1 800	1 700	1 600	1 600
ЗА	102.2	111.4	660	800	1 000	5 000	4 000	5 500	5 500	5 000	4 000	6 000	6 000	6 000	1 600	1 600	1 600	1 600
УВ	100.8	105.0	600	800	800	4 500	3 800	6 000	6 000	4 500	3 500	6 000	6 000	6 000	1 400	1 600	1 633	1 633
ХО	101.6	113.2	750	850	1 100	5 500	4 200	6 500	6 500	5 000	4 200	6 500	6 500	6 500	1 600	1 600	1 700	1 700
Хангайн бүс																		
АР	100.5	107.0	500	690	680	4 500	3 800	7 200	7 200	4 500	4 300	4 500	7 500	7 500	1 500	1 600	1 800	1 800
БХ	101.8	108.1	750	750	850	5 500	4 200	5 500	5 500	4 500	3 800	4 500	6 500	6 500	1 800	1 600	1 600	1 600
БУ	100.3	104.9	460	660	880	4 500	3 500	7 500	7 500	4 500	4 500	4 500	7 500	7 500	1 800	1 800	1 800	1 800
ОР	100.4	113.1	440	650	640	4 500	4 200	7 033	7 033	5 000	4 500	4 500	7 733	7 733	1 600	1 550	1 667	1 667
ӨВ	100.1	104.4	600	800	720	5 800	4 300	6 000	6 000	6 000	4 800	6 000	7 633	7 633	1 600	1 700	1 600	1 600
ХӨ	100.7	107.6	700	800	800	5 000	3 800	6 500	6 500	5 000	3 800	6 500	7 000	7 000	1 700	1 800	1 900	1 900
Төвийн бүс																		
ГС	102.2	112.4	520	747	750	4 000	3 800	5 900	5 900	4 000	4 000	4 000	6 500	6 500	1 800	1 500	1 400	1 400
ДА	100.4	109.4	600	810	810	4 800	3 800	7 000	7 000	5 800	4 700	5 800	8 000	8 000	1 800	1 700	1 700	1 700
ДО	101.6	112.3	490	750	687	3 900	4 300	6 550	6 550	4 800	5 000	4 800	7 800	7 800	1 600	1 500	1 567	1 567
ДУ	99.8	106.1	625	870	787	5 650	4 500	6 300	6 300	-	-	-	-	-	1 565	1 560	1 550	1 550
ӨМ	99.9	105.9	-	800	900	-	5 000	7 000	7 000	-	-	-	-	-	1 600	1 450	1 800	1 800
СЭ	102.6	112.7	600	750	800	4 000	3 800	6 867	6 867	4 400	4 500	4 500	7 867	7 867	1 600	1 600	1 667	1 667
ТӨ	101.3	107.1	480	650	620	5 300	3 700	6 800	6 800	5 800	4 000	4 000	7 000	7 000	1 650	1 600	1 600	1 600
Зүүн бүс																		
ДД	100.5	112.4	530	640	700	4 800	4 000	6 700	6 700	5 700	4 800	4 800	7 800	7 800	1 500	1 400	1 500	1 500
СҮ	100.2	105.7	600	730	730	4 200	4 000	6 000	6 000	4 000	4 500	4 500	7 000	7 000	1 500	1 500	1 480	1 480
ХЭ	100.5	107.9	600	930	800	4 500	4 000	6 800	6 800	5 500	5 000	5 500	7 800	7 800	1 700	1 600	1 600	1 600
Улаанбаатар																		
УБ	101.0	109.5	536	715	690	5 120	4 105	7 190	7 190	5 570	4 665	5 570	7 750	7 750	1 580	1 675	1 675	1 675



Хавсралт № 3-ийн үргэлжлэл

	ХҮИ, %		Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, төг															
	2012.V 2012.IV	2012.V 2011.XII	Шингэн сү. л				Элсэн чихэр, кг				Ногоон цай, 2 кг				Төмс, кг			
			2010.V	2011.V	2012.V		2010.V	2011.V	2012.V		2010.V	2011.V	2012.V		2010.V	2011.V	2012.V	
			2010.V	2011.V	2012.V		2010.V	2011.V	2012.V		2010.V	2011.V	2012.V		2010.V	2011.V	2012.V	
Баруун бүс																		
БӨ	101.3	107.8	1 700	1 500	1 500	1 800	1 900	1 733	3 500	3 700	4 266	700	1 000	500	1 800	1 166	1 200	
ГО	99.1	107.8	1 800	1 300	1 600	1 800	1 700	1 700	5 000	5 500	5 500	600	800	600	1 500	1 200	1 500	
ЗА	102.2	111.4	1 800	1 600	1 700	1 800	1 800	1 700	3 500	3 800	3 800	800	600	900	1 500	1 500	1 500	
УВ	100.8	105.0	1 500	1 000	1 000	1 800	1 800	1 700	4 500	5 000	4 833	600	800	767	2 000	1 500	1 500	
ХО	101.6	113.2	1 800	1 600	1 500	1 800	1 800	1 767	4 800	4 800	5 000	600	500	500	1 600	1 500	1 500	
Хангайн бүс																		
АР	100.5	107.0	2 000	1 500	1 500	1 500	1 700	1 800	3 300	3 300	2 500	900	900	900	1 200	1 000	1 000	
БХ	101.8	108.1	1 800	1 500	1 200	1 600	1 800	1 800	4 000	4 300	4 500	700	800	800	1 500	1 200	1 200	
БУ	100.3	104.9	1 300	1 200	1 000	1 700	1 800	1 800	3 500	3 500	3 500	600	800	800	1 000	1 100	1 000	
ОР	100.4	113.1	1 300	1 200	1 200	1 350	1 500	1 600	3 500	5 000	4 500	800	800	600	1 200	1 000	1 200	
ӨВ	100.1	104.4	-	2 000	1 600	1 500	1 800	1 600	4 500	4 500	4 233	800	800	800	1 000	850	850	
ХӨ	100.7	107.6	1 500	1 500	1 200	1 600	1 700	1 800	5 200	5 200	5 200	800	700	967	1 500	1 400	1 233	
Төвийн бүс																		
ГС	102.2	112.4	1 500	1 600	1 100	1 600	1 500	1 500	3 000	3 000	3 900	750	750	750	900	900	650	
ДА	100.4	109.4	1 100	900	850	1 550	1 700	1 700	4 500	4 500	3 800	700	750	800	1 300	1 000	1 000	
ДО	101.6	112.3	1 800	1 800	2 000	1 500	1 550	1 550	4 500	4 500	5 000	770	900	800	1 200	1 000	1 000	
ДУ	99.8	106.1	-	1 700	1 500	1 525	1 600	1 590	4 550	3 700	3 767	950	920	927	1 300	850	917	
ӨМ	99.9	105.9	-	1 500	2 500	1 633	1 733	1 800	4 450	4 450	4 300	1 300	1 000	1 200	1 700	1 200	1 300	
СЭ	102.6	112.7	1 200	700	933	1 800	1 600	1 667	4 000	4 200	4 967	600	800	1 167	1 500	2 000	1 067	
ТӨ	101.3	107.1	1 200	1 100	1 000	1 600	1 700	1 500	4 500	4 200	4 800	1 000	850	1 000	1 130	900	900	
Зүүн бүс																		
ДД	100.5	112.4	1 100	800	1 000	1 600	1 500	1 600	3 550	3 600	3 800	700	600	700	1 000	700	800	
СҮ	100.2	105.7	1 500	1 200	1 200	1 500	1 700	1 500	3 600	3 500	3 800	800	900	800	1 100	800	800	
ХЭ	100.5	107.9	1 300	1 000	1 200	1 500	1 600	1 600	4 500	5 000	4 200	700	1 000	1 000	1 200	1 200	960	
Улаанбаатар																		
УБ	101.0	109.5	1 292	1 010	1 130	1 590	1 665	1 660	4 740	4 265	4 240	900	1 015	1 070	1 207	955	1 000	



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар

төг

Аймаг, нийслэл	Үхрийн 1 ширхэг ширний дундаж үнэ					
	2 м-ээс доош урттай			2 м-ээс дээш урттай		
	2011 V	2012 IV	2012 V	2011 V	2012 IV	2012 V
	Баруун бүс					
БӨ	10 000	12 500	20 000	10 000	-	-
ГО	-	17 000	16 000	10 000	26 000	25 000
ЗА	12 500	25 000	20 700	14 500	28 000	25 000
УВ	-	23 000	20 000	-	25 000	23 000
ХО	12 000	-	-	-	22 000	15 000
	Хангайн бүс					
АР	18 000	24 000	25 000	26 000	38 000	35 000
БХ	16 000	25 000	-	-	28 000	30 000
БУ	11 500	25 000	23 500	20 000	32 000	33 500
ОР	15 000	26 000	20 000	23 000	35 000	30 000
ӨВ	-	25 000	25 000	17 000	30 000	32 000
ХӨ	18 000	25 000	25 000	22 000	-	30 000
	Төвийн бүс					
ГС	10 000	15 000	-	25 000	30 000	25 000
ДА	10 000	25 000	-	23 000	30 000	20 000
ДУ	-	15 300	12 700	-	20 300	20 700
СЭ	14 000	20 000	20 000	25 000	30 000	30 000
ТӨ	18 500	35 000	28 000	26 500	40 000	32 000
	Зүүн бүс					
ДД	17 500	18 700	20 000	19 500	28 000	25 000
СҮ	12 500	25 000	22 500	23 500	30 000	30 000
ХЭ	15 000	28 000	26 000	-	-	-
	Улаанбаатар					
УБ	18 500	30 000	25 000	30 000	42 000	40 000

Хавсралт № 4-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ		
	2011 V	2012 IV	2012 V
	Баруун бүс		
БӨ	20 000	20 000	20 000
ГО	15 000	28 700	-
ЗА	20 000	30 000	30 000
УВ	-	20 000	-
ХО	-	20 000	15 000
	Хангайн бүс		
АР	26 000	26 000	20 000
БХ	-	35 000	25 000
БУ	20 000	25 000	25 000
ОР	22 000	30 000	23 000
ӨВ	20 000	35 000	25 000
ХӨ	25 000	25 000	20 000
	Төвийн бүс		
ГС	25 000	-	25 000
ДА	24 000	28 000	25 000
ДУ	20 500	29 000	23 000
ӨМ	18 000	20 000	-
СЭ	25 000	25 000	20 000
ТӨ	26 500	35 000	28 000
	Зүүн бүс		
ДД	20 500	30 000	20 000
СҮ	24 000	25 000	22 500
ХЭ	25 000	30 000	27 000
	Улаанбаатар		
УБ	28 000	35 000	25 000



Хавсралт № 4-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Ямааны 1 кг ноолуурын дундаж үнэ					
	Цагаан			Бор		
	2011 V	2012 IV	2012 V	2011 V	2012 IV	2012 V
	Баруун бүс					
БӨ	56 000	35 000	43 000	56 000	35 000	43 000
ГО	55 000	42 000	42 000	55 000	42 000	42 000
ЗА	56 500	42 300	43 500	56 500	43 300	43 500
УВ	54 000	43 000	43 000	-	42 000	43 000
ХО	53 000	40 000	41 000	-	-	-
	Хангайн бүс					
АР	55 000	48 000	45 000	55 000	48 000	45 000
БХ	55 000	45 000	43 000	55 000	40 000	42 500
БУ	-	48 500	-	42 500	51 500	40 500
ОР	50 000	49 000	40 000	50 000	50 000	40 000
ӨВ	55 000	47 000	44 000	55 000	47 000	44 000
ХӨ	56 000	53 000	46 000	58 000	53 000	48 000
	Төвийн бүс					
ГС	47 500	45 000	40 000	-	-	-
ДА	50 000	45 000	42 000	50 000	45 000	42 000
ДО	50 000	46 000	41 000	50 000	46 000	41 000
ДУ	-	42 300	42 300	51 000	-	-
ӨМ	52 000	42 000	-	52 000	-	-
СЭ	45 000	45 000	35 000	45 000	40 000	35 000
ТӨ	52 500	45 000	45 000	52 500	45 000	45 000
	Зүүн бүс					
ДД	49 500	39 700	35 000	-	39 700	35 000
СҮ	47 500	44 000	37 500	40 000	44 000	35 000
ХЭ	40 000	40 000	-	-	-	-
	Улаанбаатар					
УБ	58 000	43 000	41 000	45 000	43 000	41 000

Хавсралт № 4-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Хонины 1 ширхэг ноостой нэхийний дундаж үнэ		
	2011 V	2012 IV	2012 V
	Баруун бүс		
БӨ	8 000	5 000	4 500
ГО	10 500	-	7 500
ЗА	10 000	10 000	10 000
УВ	8 000	11 000	8 000
ХО	5 000	12 000	6 000
	Хангайн бүс		
АР	11 000	8 000	8 000
БХ	10 500	10 000	8 000
БУ	5 500	8 000	8 000
ОР	9 500	7 000	7 500
ӨВ	10 000	7 000	5 000
ХӨ	10 500	6 000	8 000
	Төвийн бүс		
ГС	8 000	10 000	9 000
ДА	6 000	9 000	8 000
ДО	-	8 000	5 000
ДУ	11 000	10 300	7 000
ӨМ	8 000	8 000	-
СЭ	5 000	7 000	6 500
ТӨ	9 000	12 000	9 000
	Зүүн бүс		
ДД	7 500	9 300	7 000
СҮ	5 000	6 500	5 500
ХЭ	10 000	10 000	7 000
	Улаанбаатар		
УБ	7 000	7 000	6 000



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА
(жил бүрийн эхний 5 сарын байдлаар)

сая төг

	2011 I-V		2012 I-V	
	дүн	дүнд эзлэх хувь	дүн	дүнд эзлэх хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1 571 004.6	100.0	1 845 434.9	100.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	40 680.0	2.6	25 482.2	1.4
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1 530 324.6	97.4	1 819 952.7	98.6
УРСГАЛ ОРЛОГО	1 526 247.5	97.2	1 813 938.7	98.3
ТАТВАРЫН ОРЛОГО	1 353 185.0	86.1	1 629 022.7	88.3
1. Орлогын албан татвар	308 409.2	19.6	344 718.2	18.7
- Аж ахуйн нэгжийн	175 635.6	11.2	221 914.9	12.0
- Хүн амын	77 302.0	4.9	122 798.5	6.7
- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн	55 471.5	3.5	4.8	0.0
2. Нийгмийн даатгалын шимтгэл	164 368.3	10.5	246 409.3	13.4
3. Өмчийн татвар	5 750.6	0.4	7 579.0	0.4
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	493 080.3	31.4	604 795.4	32.8
- Нэмэгдсэн өртгийн татвар	359 147.3	22.9	489 563.6	26.5
- Онцгой албан татвар	118 714.4	7.6	96 127.4	5.2
- Тусгай зориулалтын орлого	15 218.5	1.0	19 104.3	1.0
5. Гадаад худалдааны орлого	119 513.7	7.6	130 670.6	7.1
6. Бусад татвар	262 063.0	16.7	294 850.2	16.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	173 062.6	11.0	184 916.1	10.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	4 077.0	0.3	4 980.0	0.3
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	-	1 034.0	0.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 481 963.5	100.0	2 224 484.9	100.0
НИЙТ ЗАРЛАГА	1 456 163.4	98.3	2 186 006.3	98.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1 257 000.4	84.8	1 782 257.8	80.1
1. Бараа, үйлчилгээний зардал	542 651.5	36.6	724 883.5	32.6
- Цалин, хөлс	324 248.8	21.9	428 991.7	19.3
- Бараа, үйлчилгээний бусад зардал	218 402.8	14.7	295 891.9	13.3
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	18 888.7	1.3	36 930.6	1.7
3. Татаас ба шилжүүлэг	695 460.2	46.9	1 020 443.7	45.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199 163.0	13.4	403 748.5	18.2
Дотоод эх үүсвэр	195 860.2	13.2	390 593.1	17.6
- Хөрөнгө оруулалт	175 540.0	11.8	358 803.5	16.1
- Их засварын зардал	14 886.7	1.0	22 687.9	1.0
- Геологи хайгуулын зардал	-	-	754.7	0.0
- Ойжуулалт, байгаль орчны бусад арга хэмжээ	1 364.6	0.1	2 147.0	0.1
- Улсын нөөц бүрдүүлэх зардал	4 068.9	0.3	6 200.0	0.3
Гадаад эх үүсвэр	3 302.8	0.2	13 155.4	0.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	25 800.1	1.7	38 478.7	1.7
- Гадаад зээлээр санхүүжих төсөл	3 881.3	0.3	10 596.5	0.5



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА
(жил бүрийн эхний 5 сарын байдлаар)

Аймаг, нийслэл	Нийт орлого			Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг		Нийт зарлага		
	2011 I-V	2012 I-V	$\frac{2012 \text{ I-V}}{2011 \text{ I-V}}$ %	2011 I-V	2012 I-V	2011 I-V	2012 I-V	$\frac{2012 \text{ I-V}}{2011 \text{ I-V}}$ %
Бүгд	211 617.8	313 155.4	148.0	13 186.8	47 434.6	131 487.9	177 660.4	135.1
	Баруун бүс							
Дүн	13 804.7	19 246.9	139.4	6 167.1	7 425.1	13 270.0	16 962.2	127.8
БӨ	2 388.2	2 995.6	125.4	1 150.0	1 570.0	2 359.8	2 667.2	113.0
ГО	2 555.1	4 567.9	178.8	111.1	239.4	2 568.3	3 220.3	125.4
ЗА	3 327.4	4 595.2	138.1	2 050.7	2 850.2	3 087.8	4 703.5	152.3
УВ	3 384.7	4 434.6	131.0	2 209.8	2 765.5	2 647.3	3 577.3	135.1
ХО	2 149.2	2 653.7	123.5	645.5	-	2 606.9	2 793.9	107.2
	Хангайн бүс							
Дүн	38 506.3	44 462.3	115.5	5 538.2	11 789.8	29 786.6	47 972.3	161.1
АР	3 181.1	4 458.9	140.2	1 868.2	2 593.0	2 390.8	3 596.3	150.4
БХ	3 095.9	4 645.2	150.0	1 750.0	2 892.3	2 658.3	3 637.9	136.9
БУ	2 103.6	3 555.5	169.0	-	1 046.6	2 004.1	2 630.0	131.2
ОР	24 835.7	22 928.8	92.3	-	-	16 797.7	30 052.8	178.9
ӨВ	1 692.1	4 171.2	246.5	-	2 701.6	2 960.8	3 863.8	130.5
ХӨ	3 597.9	4 702.8	130.7	1 920.0	2 556.3	2 974.9	4 191.4	140.9
	Төвийн бүс							
Дүн	67 294.2	82 587.9	122.7	1 481.5	3 785.6	35 353.6	46 398.4	131.2
ГС	889.0	1 930.7	217.2	165.5	702.5	1 114.0	1 660.3	149.0
ДА	3 636.0	5 097.8	140.2	-	-	2 854.5	4 197.2	147.0
ДО	3 921.0	5 858.0	149.4	-	-	2 445.6	4 277.9	174.9
ДУ	2 505.4	3 688.9	147.2	1 316.0	2 313.0	1 992.5	2 101.2	105.5
ӨМ	48 362.0	54 682.4	113.1	-	-	19 374.6	21 753.3	112.3
СЭ	4 358.4	6 442.5	147.8	-	-	4 806.9	7 564.0	157.4
ТӨ	3 622.3	4 887.7	134.9	-	770.1	2 765.6	4 844.4	175.2
	Зүүн бүс							
Дүн	8 491.7	9 911.5	116.7	-	365.2	7 115.6	8 494.3	119.4
ДД	2 741.9	3 068.5	111.9	-	-	2 037.1	2 311.2	113.5
СҮ	3 100.3	3 750.2	121.0	-	365.2	2 769.4	3 060.9	110.5
ХЭ	2 649.5	3 092.8	116.7	-	-	2 309.1	3 122.3	135.2
	Улаанбаатар							
Дүн	83 520.9	156 946.9	187.9	-	24 068.9	45 962.0	57 833.2	125.8
УБ	83 520.9	156 946.9	187.9	-	24 068.9	45 962.0	57 833.2	125.8

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО
(жил бүрийн эхний 5 сарын байдлаар)

Аймаг, нийслэл	сая төг		
	2011 I-V	2012 I-V	$\frac{2012 \text{ I-V}}{2011 \text{ I-V}}$ %
Бүгд	34 980.8	45 248.4	129.4
ДА	356.8	1 501.5	420.8
ДО	450.0	450.0	100.0
ОР	14 200.0	27 208.8	191.6
ӨМ	9 924.0	14 588.1	147.0
СЭ	850.0	1 500.0	176.5
УБ	9 200.0	-	-



Гадаад худалдааны нийт эргэлт, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлт	2011 I-V	2012 I-V	мян.ам.долл	
			2012 I-V 2011 I-V	%
Нийт бараа эргэлт	3 695 624.4	4 356 099.9		117.9
Экспорт	1 578 048.3	1 708 107.6		108.2
Валютын төлбөртэй худалдаа	1 577 276.6	1 705 905.0		108.2
Гадаадын тусламжийн бараа	128.5	169.6		132.0
Гадаадын захиалагчийн материалаар хийсэн бараа	293.9	1 243.2		423.0
Бусад	349.3	789.8		226.1
Импорт	2 117 576.1	2 647 992.3		125.0
Валютын төлбөртэй худалдаа	1 708 569.7	2 243 538.6		131.3
Бараа солилцоо	33.3	-		-
Гадаадын тусламжийн бараа	54 636.3	57 204.4		104.7
Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа	352 166.4	343 202.7		97.5
Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа	1 309.0	2 145.8		163.9
Гадаадын захиалагчийн материал, эд зүйлс	295.7	303.1		102.5
Бусад	565.7	1 597.7		282.4

Экспорт, импорт, барааны бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Барааны бүлэг	мян.ам.долл			
	2011 I-V		2012 I-V	
	Дүн	Дүнд эзлэх хувь	Дүн	Дүнд эзлэх хувь
Экспорт	1 578 048.3	100.0	1 708 107.6	100.0
Эрдэс бүтээгдэхүүн	1 343 106.8	85.1	1 537 225.6	90.0
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	115 430.6	7.3	80 182.6	4.7
Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	57 393.6	3.6	38 893.7	2.3
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	25 974.5	1.6	13 587.5	0.8
Авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	3 706.2	0.2	12 315.0	0.7
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	10 584.4	0.7	7 748.2	0.5
Мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн	9 500.4	0.6	7 644.2	0.4
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг	5 173.3	0.3	4 736.0	0.3
Бусад	7 178.5	0.6	5 774.8	0.3
Импорт	2 117 576.1	100.0	2 647 992.3	100.0
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг	559 737.4	26.4	649 415.0	24.5
Эрдэс бүтээгдэхүүн	336 144.0	15.9	604 992.0	22.8
Авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	569 036.9	26.9	603 338.8	22.8
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	182 905.0	8.6	203 505.4	7.7
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	111 822.8	5.3	131 282.7	5.0
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	84 571.7	4.0	103 922.0	3.9
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	69 863.4	3.3	89 123.8	3.4
Хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсэг	25 423.8	1.2	47 457.8	1.8
Чулуу, гөлтгөнө, цемент, шөрмөсөн чулуун зүйлс, шил, шилэн сав	31 971.0	1.5	42 391.7	1.6
Бусад	146 100.2	6.9	172 563.2	6.5

**Төллөсөн хээлтэгч, төллөлтийн хувь, жил бүрийн эхний 5 сарын байдлаар**

Малын төрөл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь		
	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Бүгд	9 195.7	11 836.8	12 851.6	48.4	76.2	81.9
Гүү	173.8	255.7	324.6	26.8	43.1	50.6
Үнээ	355.8	419.9	558.4	34.8	46.6	57.8
Ингэ	26.6	34.2	40.7	29.6	37.7	42.3
Эм хонь	4 966.5	5 786.8	6 206.2	57.3	81.5	87.2
Эм ямаа	3 673.0	5 340.1	5 721.7	42.9	78.0	83.3

Бойжуулсан төл, бойжилтын хувь, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Малын төрөл	Бойжуулсан төл, мян.толгой			Бойжилтын хувь		
	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Бүгд	6 709.5	11 561.7	12 711.6	72.8	97.4	98.7
Унага	153.6	249.3	316.2	88.4	97.5	97.8
Тугал	314.1	411.9	547.4	88.3	98.1	98.3
Ботго	24.9	33.5	40.0	93.8	97.9	98.5
Хурга	3 671.8	5 654.7	6 153.0	73.7	97.5	98.9
Ишиг	2 545.1	5 212.2	5 654.9	69.1	97.3	98.5

Зүй бусаар хорогдсон том мал, оны эхний малд хорогдлын эзлэх хувь, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал, мян.толгой			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Бүгд	8 821.0	437.1	238.4	20.0	1.3	0.7
Адуу	298.0	16.9	12.4	13.4	0.9	0.6
Үхэр	501.8	35.7	22.2	19.3	1.6	0.9
Тэмээ	7.6	0.8	0.5	2.7	0.3	0.2
Хонь	3 636.6	185.0	94.4	18.9	1.3	0.6
Ямаа	4 377.0	198.7	108.8	22.3	1.4	0.7



Мал төллөлт, төл бойжилт, зүй бусаар хорогдсон том мал, өвчнөөр хорогдсон мал, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Аймаг, нийслэл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь			Бойжуулсан төл, мян.тол			Бойжилтын хувь		
	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Дүн	9 195.7	11 836.8	12 851.6	48.4	76.2	81.9	6 709.5	11 561.7	12 711.6	72.8	97.4	98.7
	Баруун бүс											
Дүн	2 060.0	2 897.4	3 084.3	43.3	81.2	85.1	1 394.9	2 795.4	3 033.7	67.7	96.4	98.2
БӨ	370.0	460.6	482.9	61.4	88.7	85.3	320.6	448.5	473.3	86.7	97.4	97.9
ГО	148.8	548.1	579.3	16.4	80.1	87.0	81.7	530.2	573.3	54.9	96.7	98.7
ЗА	416.4	595.6	734.7	34.9	76.1	88.5	260.7	579.8	725.6	62.6	97.3	98.5
УВ	610.9	671.2	628.4	56.7	83.5	79.0	358.8	660.4	612.3	58.7	98.3	97.3
ХО	513.9	621.9	659.0	52.4	79.7	86.0	373.1	576.5	649.0	72.6	92.7	98.4
	Хангайн бүс											
Дүн	3 551.2	4 206.3	4 740.2	50.0	73.6	81.9	2 349.8	4 049.0	4 659.2	66.0	96.2	98.4
АР	919.0	1 004.0	1 108.3	60.2	81.1	86.2	564.1	940.8	1 083.8	61.4	93.7	97.8
БХ	352.2	654.0	742.2	31.6	69.8	80.7	215.2	642.5	733.5	61.1	98.2	98.6
БУ	800.3	787.8	933.1	68.1	73.1	87.3	590.7	743.5	909.1	73.5	94.4	98.6
ОР	75.1	68.6	65.4	66.6	82.1	85.8	53.2	68.4	65.0	68.7	99.4	98.9
ӨВ	487.4	726.6	836.3	34.0	77.9	86.3	271.0	712.2	837.0	55.4	97.8	99.5
ХӨ	917.3	965.3	1 054.8	52.7	66.7	71.9	655.7	941.7	1 030.7	71.5	97.5	97.7
	Төвийн бүс											
Дүн	1 908.6	2 725.8	2 856.0	42.6	74.4	78.3	1 485.9	2 717.0	2 861.6	77.6	99.1	99.4
ГС	47.2	62.0	66.7	59.7	84.6	77.5	44.2	62.4	66.4	93.8	99.7	99.2
ДА	107.2	108.8	111.7	63.3	83.7	91.2	72.7	108.3	111.3	67.5	99.4	99.6
ДО	200.6	320.0	328.1	44.9	68.9	65.4	199.0	323.2	330.7	98.6	99.9	99.9
ДУ	194.2	399.5	466.9	22.1	71.4	84.2	141.1	399.6	472.5	72.6	99.7	99.8
ӨМ	43.9	314.9	327.6	6.3	60.4	68.6	40.4	317.2	330.6	91.8	99.9	99.9
СЭ	425.5	465.7	453.9	64.7	76.9	78.2	353.7	460.9	451.9	83.1	98.9	99.5
ТӨ	890.0	1 055.0	1 101.1	57.5	80.6	83.1	634.7	1 045.3	1 098.1	70.9	98.3	99.0
	Зүүн бүс											
Дүн	1 607.3	1 899.6	2 059.2	65.1	77.7	82.3	1 423.5	1 893.4	2 046.4	88.1	99.2	99.0
ДД	321.2	402.1	372.5	49.6	74.0	75.4	246.3	399.9	368.2	76.6	99.0	98.5
СҮ	617.3	669.4	722.7	79.7	78.0	80.0	608.9	669.3	724.3	97.6	99.3	99.4
ХЭ	668.8	828.2	963.9	63.9	79.5	87.4	568.3	824.2	953.9	84.8	99.3	98.8
	Улаанбаатар											
УБ	68.5	107.7	111.9	36.0	77.6	83.8	55.4	106.9	110.8	80.8	99.1	98.7

Хавсралт № 11-ийн үргэлжлэл

Аймаг, нийслэл	Хорогдсон том мал, мян.толгой			Оны эхний малд хорогдлын эзлэх хувь			Өвчнөөр хорогдсон мал, мян.тол			Зүй бус хорогдолд өвчний хорогдлын эзлэх хувь		
	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V	2010 I-V	2011 I-V	2012 I-V
Дүн	8 821.0	437.2	238.4	20.0	1.3	0.7	72.6	14.1	13.4	0.8	3.2	5.6
	Баруун бүс											
Дүн	2 676.9	138.0	80.9	24.6	1.9	0.9	30.8	4.3	4.2	1.2	3.1	5.1
БӨ	143.7	8.7	8.7	11.0	0.8	0.7	4.5	1.5	1.3	3.1	17.3	15.3
ГО	655.7	41.5	24.2	30.2	3.2	1.5	4.0	0.7	0.3	0.6	1.8	1.3
ЗА	937.5	20.6	9.7	33.2	1.2	0.5	3.5	0.5	1.0	0.4	2.5	10.7
УВ	490.0	18.8	25.1	21.1	1.2	1.4	16.1	1.3	1.1	3.3	7.1	4.3
ХО	450.0	48.4	13.2	19.8	3.0	0.7	2.7	0.2	0.4	0.6	0.5	3.0
	Хангайн бүс											
Дүн	3 703.6	209.7	99.6	22.2	1.7	0.7	26.3	5.1	3.9	0.7	2.4	4.0
АР	895.5	84.0	48.8	24.7	3.1	1.6	6.2	0.6	0.4	0.7	0.8	0.9
БХ	407.1	13.8	11.5	15.2	0.7	0.5	1.2	0.8	0.5	0.3	5.7	4.5
БУ	188.7	55.0	12.4	7.2	2.4	0.5	2.8	2.0	1.5	1.5	3.7	12.1
ОР	27.2	0.7	0.2	10.6	0.4	0.1	6.1	0.0	0.0	22.4	6.8	27.0
ӨВ	1 573.9	18.3	4.0	43.5	0.9	0.2	2.5	0.1	0.2	0.2	0.6	4.0
ХӨ	611.2	37.9	22.6	15.6	1.2	0.7	7.5	1.5	1.3	1.2	3.9	5.6
	Төвийн бүс											
Дүн	1 926.5	37.0	22.5	18.3	0.5	0.3	12.1	3.3	3.4	0.6	8.8	15.3
ГС	12.5	0.1	0.2	7.4	0.1	0.1	-	0.0	0.0	-	1.3	23.2
ДА	43.4	1.1	0.7	12.0	0.4	0.3	0.0	0.0	0.0	0.1	1.6	3.2
ДО	37.8	1.4	7.3	3.5	0.1	0.6	0.2	0.1	0.3	0.4	8.5	3.8
ДУ	788.7	0.7	0.3	36.7	0.1	0.0	0.0	0.0	-	0.0	3.7	-
ӨМ	461.2	2.1	1.8	26.3	0.2	0.2	0.3	0.2	0.1	0.1	7.8	3.7
СЭ	96.8	5.9	2.3	6.2	0.5	0.2	1.7	0.3	0.4	1.8	5.4	18.4
ТӨ	486.2	25.7	10.0	14.0	0.9	0.3	9.8	2.6	2.6	2.0	10.2	26.3
	Зүүн бүс											
Дүн	450.4	51.2	34.0	8.2	1.0	0.6	1.9	1.1	1.3	0.4	2.1	3.9
ДД	267.5	4.7	11.3	18.4	0.4	1.0	1.0	0.2	0.3	0.4	4.7	3.1
СҮ	24.7	39.2	11.5	1.4	2.0	0.6	0.4	0.2	0.1	1.5	0.6	1.1
ХЭ	158.3	7.2	11.2	7.0	0.3	0.5	0.5	0.6	0.9	0.3	8.8	7.7
	Улаанбаатар											
УБ	63.6	1.5	1.4	15.9	0.6	0.5	1.5	0.3	0.5	2.3	20.8	37.7



**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар,
жил бүрийн эхний 5 сарын байдлаар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр**

Аж үйлдвэрийн салбар	2011 V	2012 V	2011 I-V	2012 I-V	сая төг
					$\frac{2012\ I-V}{2011\ I-V}$ %
Нийт дүн	179 807.4	187 971.5	764 126.8	834 033.0	109.1
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	98 258.5	115 193.3	443 213.2	495 018.0	111.7
Нүүрс олборлолт	21 564.2	20 789.9	106 909.3	114 938.0	107.5
Газрын тос олборлолт	11 278.7	15 330.6	50 122.3	77 394.9	154.4
Металлын хүдэр олборлолт	63 333.8	77 023.3	276 507.8	293 307.4	106.1
Бусад ашигт малтмал олборлолт	2 081.8	2 049.5	9 673.8	9 377.7	96.9
Боловсруулах аж үйлдвэр	66 069.7	57 474.9	218 044.0	231 748.7	106.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	25 252.7	26 684.3	116 623.4	127 016.2	108.9
Тамхи үйлдвэрлэл	2 622.2	2 722.8	8 019.2	7 885.4	98.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	17 107.5	5 942.4	39 616.7	27 937.5	70.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	703.1	750.5	3 102.6	2 576.6	83.0
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	1 097.6	1 654.3	1 206.3	2 022.6	167.7
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	157.2	183.4	825.6	988.7	119.8
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	235.0	385.2	915.8	1 756.4	191.8
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	1 055.9	1 561.6	4 151.9	5 359.0	129.1
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	-	-	63.9	372.3	582.2
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 854.2	2 067.8	8 159.3	8 973.3	110.0
Резин болон хуванцар бүтээгдэхүүн	266.2	929.9	855.3	3 758.7	439.5
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	7 514.2	5 967.0	14 214.5	13 882.1	97.7
Төмрийн үйлдвэрлэл	7 752.4	6 795.2	18 437.1	23 600.5	128.0
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	4.4	16.4	16.9	21.5	127.6
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	100.7	503.7	368.7	2 626.7	712.4
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	234.0	366.7	973.0	1 791.8	184.1
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	7.0	0.6	62.5	3.4	5.4
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	105.6	943.0	431.2	1 176.0	272.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	15 479.2	15 303.3	102 869.6	107 266.3	104.3
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	14 293.4	14 126.9	97 008.2	101 415.4	104.5
Ус ариутгал, усан хангамж	1 185.8	1 176.4	5 861.4	5 850.9	99.8



**Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
жил бүрийн эхний 5 сарын байдлаар**

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2011 V	2012 V	2011 I-V	2012 I-V	$\frac{2012 \text{ I-V}}{2011 \text{ I-V}} \%$
Цахилгаан эрчим хүч	сая кВт.цаг	297.0	294.7	1 666.9	1 778.4	106.7
Дулааны эрчим хүч	мян.Гкал	324.6	313.1	4 552.2	4 518.4	99.3
Газрын тос	мян.баррел	206.1	280.2	916.1	1 414.5	154.4
Нүүрс	мян.т	2 058.2	1 984.3	10 204.0	10 970.3	107.5
Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр	мян.т	33.7	34.7	149.2	150.7	101.0
Молибдений баяжмал, 47%- ийн агуулгад шилжүүлснээр	т	336.3	341.9	1 768.2	1 743.1	98.6
Хайлуур жоншны баяжмал	мян.т	11.0	10.9	52.2	51.7	99.0
Алт	кг	497.6	498.7	2 026.9	1 497.0	73.9
Катодын зэс, 99%	т	209.0	191.5	1 008.3	926.1	91.8
Сүлжмэл эдлэл	мян.ш	59.4	64.9	263.7	258.0	97.8
Самнасан ноолуур	т	250.5	18.0	378.7	101.5	26.8
Хивс	мян.м ²	67.1	74.2	324.2	387.0	119.4
Тэмээний ноосон хөнжил	мян.м	0.2	0.3	10.5	2.5	23.8
Зүсмэл материал	м ³	890.3	148.3	2 628.0	2 101.1	80.0
Шохой	мян.т	5.2	5.4	12.7	24.0	189.0
Сонин	сая х.д.х	3.3	5.0	15.6	20.7	132.7
Малын мах	т	1.7	7.2	537.1	1 189.3	221.4
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	174.6	172.8	820.5	784.8	95.6
Гурил	т	8 722.1	6 251.6	45 442.6	30 725.3	67.6
Талх	т	1 739.3	2 117.4	8 508.4	10 044.1	118.0
Нарийн боов	т	1 080.6	1 113.8	4 954.3	5 402.7	109.1
Гоймон	т	231.1	4.9	756.3	448.4	59.3
Амтат ус, ундаа	мян.л	6 898.5	7 776.4	24 056.0	28 518.0	118.5
Архи, дарс	мян.л	2 075.5	2 007.9	10 870.3	10 954.4	100.8
Спирт	мян.л	288.1	262.6	1 679.5	1 892.6	112.7



**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар,
оны үнээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар**

Аж үйлдвэрийн салбар	2011 I-V	2012 I-V	Үүнээс: гадаадад	сая төг	
				Дүнд эзлэх хувь	
				2011 I-V	2012 I-V
Аж үйлдвэр бүгд	1 890 740.7	2 322 759.8	1 539 170.6	100.0	100.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 299 959.3	1 398 387.4	1 260 269.3	68.8	60.2
Нүүрс олборлолт	396 486.9	397 081.4	336 393.6	21.0	17.1
Газрын тос олборлолт	106 825.1	176 020.7	176 020.7	5.6	7.6
Металлын хүдэр олборлолт	770 275.8	798 128.4	722 810.6	40.7	34.4
Бусад ашигт малтмал олборлолт	26 371.5	27 157.0	25 044.5	1.4	1.2
Боловсруулах аж үйлдвэр	409 350.9	714 919.0	278 901.3	21.6	30.8
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	221 230.0	281 499.4	2 570.7	11.7	12.1
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	17 165.0	28 630.0	2 297.3	7.8 *	10.2 *
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13 512.4	16 862.5	-	6.1 *	6.0 *
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	36 578.4	24 455.4	-	16.5 *	8.7 *
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	25 394.6	30 701.2	-	11.5 *	10.9 *
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	128 579.7	180 850.3	273.3	58.1 *	64.2 *
Тамхи үйлдвэрлэл	15 900.0	16 826.8	-	0.8	0.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	61 363.6	48 965.7	26 232.0	3.2	2.1
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	4 170.3	3 533.0	-	0.2	0.2
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	828.9	881.9	274.7	0.0	0.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	3 207.2	4 320.8	-	0.2	0.2
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	6 188.6	8 468.1	-	0.3	0.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 124.6	5 228.5	-	0.2	0.2
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	84.5	213 248.4	212 595.0	0.0	9.2
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	12 683.9	22 164.3	-	0.7	1.0
Резин болон хуванцар бүтээгдэхүүн	340.3	1 222.0	-	0.0	0.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	41 102.0	32 920.2	-	2.2	1.4
Төмрийн үйлдвэрлэл	32 502.7	60 554.6	37 019.4	1.7	2.6
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	3 404.7	10 270.1	207.7	0.2	0.4
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	561.7	2 052.9	-	0.0	0.1
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	136.5	806.2	-	0.0	0.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл	121.8	88.1	-	0.0	0.0
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	895.6	1 073.1	-	0.0	0.0
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	504.1	794.8	1.9	0.0	0.0
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	181 430.5	209 453.4	-	9.6	9.0
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	164 573.1	191 529.3	-	8.7	8.2
Ус ариутгал, усан хангамж	16 857.3	17 924.1	-	0.9	0.8

Тайлбар: * Бүлгийн дүнд эзлэх хувь



**Төмөр зам, агаарын тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн
эхний 5 сарын байдлаар**

Тээврийн төрөл, үзүүлэлтүүд	2010	2011	2012	2012 I-V	%
	I-V	I-V	I-V	2011 I-V	
I. Төмөр замын тээвэр					
Тээсэн ачаа, мян.т	6 137.0	7 009.0	8 336.4		118.9
дотоодын	3 210.7	3 400.8	3 864.4		113.6
гаргалт	1 405.9	2 117.6	2 907.0		137.3
оруулалт	553.3	648.9	907.5		139.8
дамжин өнгөрөх	967.0	841.7	657.6		78.1
Ачаа эргэлт, сая т.км	3 590.4	4 239.3	5 081.0		119.9
дотоодын	973.0	1 091.4	1 241.2		113.7
гаргалт	1 281.4	1 877.1	2 648.4		141.1
оруулалт	262.6	336.7	461.5		137.1
дамжин өнгөрөх	1 073.4	934.2	729.9		78.1
Зорчигчдын тоо, мян.хүн	1 361.6	1 479.4	1 594.5		107.8
олон улсад зорчсон	40.9	49.0	49.3		100.6
дотоодод зорчсон	1 320.8	1 430.4	1 545.2		108.0
Зорчигч эргэлт, сая хүн км	445.1	517.1	555.3		107.4
Шилжүүлсэн сая т.км	4 035.5	4 756.5	5 636.4		118.5
Тээврийн орлого, оны үнээр, сая төг	105 890.2	139 818.8	172 271.1		123.2
II. Агаарын тээвэр					
Тээсэн ачаа, т	549.7	700.1	1 480.4		211.5
шуудан	149.3	169.4	184.9		109.1
тээш	91.4	121.1	149.4		123.3
ачаа	309.0	409.6	1 146.2		279.8
Ачаа эргэлт, мян.т.км	1 169.7	1 467.9	3 769.0		256.8
шуудан	264.0	309.0	349.1		113.0
тээш	136.5	187.7	211.4		112.6
ачаа	769.2	971.2	3 208.6		330.4
Зорчигчдын тоо, мян.хүн	116.7	179.5	256.3		142.8
олон улсад зорчсон	84.0	119.5	153.8		128.7
дотоодод зорчсон	32.7	60.0	102.5		170.8
Зорчигч эргэлт, сая хүн км	191.7	286.7	409.5		142.9
Шилжүүлсэн сая т.км	18.5	27.5	40.9		148.9
Тээврийн орлого, оны үнээр, сая төг	37 006.3	46 293.7	59 007.8		127.5



ЖЕНДЕРИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүний нийгмийн хөгжлийн орчин цагийн хэрэгцээ нь хувь хүний эрхийг хүндэтгэх, ялангуяа хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, түүний дотор хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг арилгах буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийн жендерийн тэгш эрх, тэгш байдлыг тогтоохыг шаардаж байна.

Дэлхийн улс орны удирдагчид, төрийн тэргүүн нар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 онд болсон тусгай чуулганд оролцоходоо хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй олон асуудлыг хэлэлцэн “Мянганы тунхаглал”-ыг батлан гаргасан. Энэхүү тунхаглалаар аль ч улс орны төрөөс ард иргэдийнхээ ая тухтай, аюулгүй, сайн сайхан амьдралын баталгааг хангахад хамгийн чухал суурь асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийг хангах, гэр бүл, нийгмийн харилцаанд тэдний эрхийг дээдэлж, баталгаажуулах явдал хэмээн үзсэн юм.

Олон улсад хэрэглэдэг нийтлэг ойлголтоор жендер нь тодорхой нэг соёл, иргэншил, газар нутаг, нийгэм, цаг хугацаанд эрэгтэй, эмэгтэйчүүдэд нийгмийн зүгээс оноосон үүрэг, хариуцлага юм. Хүйс гэдэг нэр томъёо нь хүний биологийн шинж чанаруудтай холбоотой учир тэдгээр шинж нь төрөлхийн уг чанарт хамаардаг, өөрчлөх боломжгүй байдаг.

Жендерийн тэгш байдал гэдэг нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх эрхтэйг илэрхийлдэг.¹

Монгол Улсын “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” -д **жендер** гэсэн ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

... “улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг”;

... **“жендерийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.**

Сүүлийн жилүүдэд монгол улсад эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдах бодит байдалд тэгш бус хандлага ажиглагдаж буйг анхаарахгүй өнгөрч болохгүй. Монгол улсын хууль тогтоомжид жендерийн холбогдолтой хэд хэдэн үзүүлэлтийг тусгасан байдаг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн төлөв байдлыг багцлан харууллаа.

I. ХҮН АМ, ГЭР БҮЛ, ӨРХ

Хүн амын насны бүтцийг хүйсийн ялгаатайгаар судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг тольдох, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Энэ нь хүйсийн биологийн ялгааг харуулаад зогсохгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн үүрэг хариуцлагын ялгаатай байдлыг ерөнхийд нь дүгнэх бололцоо өгдөг.


¹ “Жендерийн тэгш байдал” Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогын сэдэвчилсэн судалгаа, 2011 он



2011 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хүн амын тоо 1364.7 мянга буюу 48.5 хувийг эрэгтэйчүүд, 1446.7 мянга буюу 51.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж, хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 94.3 байна.

Зураг 1.


Хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2011 он



Сүүлийн жилүүдэд нийт хүн амын дунд 15-64 насны хүн амын эзлэх хувийн жин нэмэгдэж, 2011 оны жилийн эцсийн байдлаар 68.8 хувийг эзэлж байгаа бол 27.2 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 4.0 хувийг 65, түүнээс дээш насныхан эзэлж байна. Үүнийг 2007 оныхтой харьцуулахад 15 хүртэлх насны хүн амын эзлэх хувь 1.4 пункт, 65, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь 0.1 пунктээр буурч, 15-64 насны хүн амын эзлэх хувь 1.5 пунктээр өсчээ.

Зураг 2.

Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 2000-2011 он




Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь хүн амын эрүүл мэндийн байдлын талаарх нэг гол үзүүлэлт билээ. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн төрөлтөөс тооцсон дундаж наслалтын ялгаа 2000 онд 5.7 жил байснаа 2011 онд 3.4 пунктээр нэмэгдэж, 9.1 жил болсон байна.



Хүн амын амьжиргааны түвшинг илтгэх нэг чухал үзүүлэлт бол ядуурлын хамралтын хүрээ юм. Ядуурлын хамралтын хүрээг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзвэл Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны судалгаагаар эрэгтэй тэргүүлэгчтэй өрх ядууралд арай бага өртдөг байсан бол өрхийн нийгэм, эдийн засгийн сүүлийн 3 удаагийн судалгааны дүнгээр эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдтэй ойролцоо болсон байна.

Зураг 3.

Ядуурлын хамралтын хүрээ, хот, хөдөө, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, хувиар, 2002-2003, 2007-2008, 2010, 2011 он



*-Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа

Гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад чухал ач холбогдолтой учир Монгол улсын удаа дараагийн хүн амын тооллогоор гэрлэлтийн талаар холбогдох мэдээллийг байнга цуглуулж ирсэн.

Улсын хэмжээнд хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогоор эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор хоёр насны зөрүүтэй, өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2 жилийн өмнө гэрлэж байна.

Хүснэгт 1.

Анхны гэрлэлтийн дундаж нас, хот, хөдөө, хүйсээр, 2000, 2010 он

	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
2000	25.7	23.7	26.1	24.6	25.2	22.3
2010	26.2	24.2	26.3	24.9	26.0	22.4

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын байдлаар улсын дунджаар эмэгтэйчүүд 23.7 насандаа, эрэгтэйчүүд 25.7 насандаа анх гэр бүл болж байсан бол 2010 онд эмэгтэйчүүд 24.2 насандаа, эрэгтэйчүүд 26.2 насандаа анх гэр бүл болж байна. Сүүлийн жилүүдэд эрэгтэй, эмэгтэйчүүд орой гэрлэж байгаа нь нэг талаас зах зээлийн өнөөгийн нөхцөлд гэр



бүл болох бэлтгэл, эдийн засгийн боломжоо хангах, сурч боловсрох зэрэг олон шалтгаанаас хамаарч байж болох ба нөгөө талаас залуучуудын үүрэг хариуцлага, ухамсар, амьдрах ухаанд өөрчлөлт гарсантай ч холбоотой байж болох талтай.

Хотын эмэгтэйчүүд нь хөдөөгийн эмэгтэйчүүдийг бодвол 2 насаар орой гэрлэж байна.

II. Боловсрол

Монгол улс нь бүх иргэдээ тэгш эрх, боломж нөхцлөөр хангах талаар түүхэн уламжлалтай орон бөгөөд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлдэг. Тийм ч учраас өнөөдөр Монгол улсын эмэгтэйчүүдийн байдал олон талаараа хөгжингүй орны эмэгтэйчүүдийн байдалтай адил төстэй, харин хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүдийн байдлаас хавьгүй дээр байгаа юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.3 хувь байгаа нь 2000 оныхоос 0.5 пунктээр өссөний дотор эрэгтэйчүүдийнх 0.2 пункт, эмэгтэйчүүдийнх 0.8 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 2.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр, хувиар, 2000, 2010 он

Байршил	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	97.8	98.0	97.5	98.3	98.2	98.3
Хот	98.9	99.0	98.7	99.1	99.1	99.1
Хөдөө	96.2	96.6	95.8	96.3	96.3	96.3

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин хот, хөдөөд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байгаа боловч 2000 онд хотын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин хоёр хүйсийн хувьд хөдөөгийнхөөс 2.5-2.9 пункт, 2010 онд 2.8 пунктээр дээгүүр байна.

Хүснэгт 3.

15-24 насны залуучуудын бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хүйсээр хувиар, 2000, 2010 он

Бичиг үсгийн мэдлэг	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бичиг үсэг мэддэг 15-24 насны залуучууд	97.7	97.0	98.4	98.5	98.0	98.9
Бичиг үсэг мэддэггүй 15-24 насны залуучууд	2.3	3.0	1.6	1.5	2.0	1.1

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 15-24 насны залуучуудын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.5 хувь байгаа нь 2000 оныхоос 0.8 пунктээр өссөний дотор эрэгтэйчүүдийнх 1.0 пункт, эмэгтэйчүүдийнх 0.5 пунктээр нэмэгджээ.

Улс орны хөгжил дэвшилд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангаж, тэднийг нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх нь хүн амын амьдралын чанарыг сайжруулах, нийгэм дэх сөрөг үзэгдлийг арилгахад ач холбогдолтой юм.


90-ээд оны эхэн үед тохиолдсон эдийн засгийн шилжилтийн байдал нь боловсролд таагүй нөлөө үзүүлсэн хэдий ч сүүлийн үед байдал сайжрах хандлагатай байна. Дээд



боловсрол эзэмшихээр 2000 онд суралцаж байсан оюутнуудын 36.8 хувь нь эрэгтэйчүүд байсан бол 2011 онд 41.2 хувь болж өссөн байна.

Зураг 4.

Бага, дунд, дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн хүйсийн харьцаа*, 2000-2011 он



* 100 эрэгтэйд ногдох эмэгтэй хүн ам

Бага, дунд боловсрол эзэмшигчдийн дунд хүйсийн харьцаа тэнцвэржвэл улмаар дээд боловсрол эзэмшигчдийн дунд хүйсийн ялгаа арилж, МХЗ биелэгдэх боломжтой болно. Бага боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн хүйсийн харьцаа 2011 онд 0.95, дунд боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн хүйсийн харьцаа 1.06, дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа 1.43 байна. Энэ нь боловсролын шат ахих тусам эмэгтэйчүүдийн хамрагдалт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад өндөр байгааг харуулж байгаа боловч сүүлийн 11 жилийн байдлаар энэхүү харьцаа буурах хандлагатай байна.

III. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулинд нас, хүйсээр ялгаварлахын эсрэг тодорхой заалтуудыг тусгасан байдаг. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг хүйсийн ялгаатайгаар судлах нь эдийн засагт эмэгтэйчүүдийн оруулах хувь нэмрийг судлах боломжийг олгодог.


Ажиллах хүчний 2011 оны судалгааны дүнгээр эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 1124.7 мянга, үүнээс 529.2 мянга буюу 47.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн 11 жилийн хугацаанд тогтвортой байж, 2011 онд улсын дундаж түвшин 62.5 хувьд хүрч, 2000 оныхоос 0.4 пункт, 2010 оныхоос 0.9 пунктээр өссөн байна. Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс дээгүүр байна.



Зураг 5.

Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, 2000-2011 он




Ажиллагчдыг салбараар ангилж үзвэл хөдөө аж ахуй, худалдааны салбарт хүмүүс олноор ажиллаж байгаа бөгөөд хүйсийн харьцаа ерөнхийдөө ойролцоо, харин зарим салбарт аль нэг хүйс нь зонхилж байна. Ажиллах хүчний 2010 оны судалгааны дүнгээс үзэхэд байр, орон сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд зонхилж байхад уул уурхайн олборлолт, цахилгаан, хий уур, агааржуулалтын хангамж, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын даатгалын салбарт эрэгтэйчүүд илүү зонхилж байна.

Ажиллах хүчний 2010 оны судалгааны дүнгээр хөдөлмөр эрхэлж буй таван хүн тутмын хоёр нь цалин хөлстэй ажиллагч байхад хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгч тус бүр таван хүний нэг нь байна. Нийт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн 46.8 хувь нь цалин хөлстэй ажиллагч байхад эрэгтэйчүүдийн 38.5 хувь нь цалин хөлстэй ажиллагч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах ажлын хүрээнд олон төрлийн арга хэмжээ авч явуулж байгаагийн үр дүнд сүүлийн жилүүдэд ажилгүйдлийн түвшин буурч байгаа ба Ажиллах хүчний 2011 оны судалгааны дүнгээр 7.7 хувь болж, 2010 оныхоос 2.2 пункт, 2009 оныхоос 3.9 пунктээр буурсан байна.

Зураг 6.

Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, хувиар, 2002-2003, 2006-2007, 2007-2008, 2008-2009, 2009, 2010, 2011 он





Монгол улсад албан бус секторт хөдөлмөр эрхлэлт нь хүн амын орлогын эх үүсвэр бүрдүүлэлтийн нэлээд хэсгийг хангадаг. Ажиллах хүчний 2010 оны судалгааны дүнгээр улсын хэмжээнд албан бус секторт ажиллагчдын тоо 154.3 мянга байгаагийн 59.0 хувь буюу 91.1 мянга нь эрэгтэй байна. Албан бус секторт ажиллагч 100 эрэгтэйд 69 эмэгтэй ногдож байна. Албан бус секторт ажиллагчдын хүйсийн харьцаа 2010 онд 2002-2003 оны судалгааны дүнгээс 0.12 пунктээр буурсан байна.

Хүснэгт 4.

**Албан бус секторт ажиллагчдын хүйсийн харьцаа*,
2002-2003, 2007-2008, 2008-2009, 2010 он**


	2002-2003	2007-2008	2008-2009	2010
Хүйсийн харьцаа	0.81	0.80	0.69	0.69

* 100 эрэгтэйд ногдох эмэгтэй хүн ам

Ажиллах хүчний 2010 оны судалгааны дүнгээр албан бус секторт хөдөлмөр эрхэлсэн нийт хүн амын ихэнх буюу 59.1 мянга (38.3 хувь), үүнээс 35.8 мянган эмэгтэй худалдаа, үйлчилгээний ажил эрхэлсэн байна. Нийт хөдөлмөр эрхлэгчдийн 28.1 хувийг үйлдвэрийн ажилчид эзэлж байгаагийн 59.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагчаар 29.4 мянган хүн ажилласан нь 19.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ мэргэжлээр эрэгтэйчүүдийн ихэнх буюу 30.9 хувь нь хөдөлмөр эрхэлсэн байна.

Зураг 7.

Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, хувиар, 2000-2011 он




ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхлэгчдийн дотор эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа ч 2011 оны байдлаар эмэгтэйчүүдийн сарын дундаж цалингийн түвшин эрэгтэйчүүдийн сарын дундаж цалингаас 18.9 орчим хувиар доогуур байна.



Зураг 8.

ХАА-с бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2000-2011 он



Эмэгтэйчүүд бөөний ба жижиглэн худалдаа, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн гүйлгээ зэрэг хөнгөн салбарт, харин эрэгтэйчүүд уул уурхай, барилга, зам тээвэр зэрэг өндөр бүтээмжтэй салбарт зонхилж байгаа нь тэдний цалин хөлсний түвшинд нөлөөлж байна.

IV. Эрүүл мэнд, хоол тэжээл

Хоол тэжээлийн байдлын гурван шалгуур үзүүлэлтийг тав хүртэлх насны хүүхдийн өсөлт, хөгжилтийн хэвийн байдлыг үнэлэх өндөр, жингийн тархалтын стандарт² голч утгаас хэлбэлзэх хазайлтаар тодорхойлдог.

Тухайн насны хүүхдийн биеийн жин нь стандарт жингийн голчоос хэлбэлзэх стандарт хазайлтыг (СХ) 2 дахин авснаас доогуур байвал дунд хэлбэр, стандарт хазайлтыг 3 дахин авснаас доогуур байвал тураалын хүнд хэлбэр гэж үздэг.

“Хүүхэд хөгжил – 2000” судалгааны дүнгээр тав хүртэлх насны хүүхдийн 12.7 хувь нь дунд хэлбэрийн тураалтай байсан бол 2010 онд 4.7 хувь болж, 8.0 пунктээр буурсан байна. “Хүүхэд хөгжил – 2010” судалгааны дүнгээр тав хүртэлх насны эрэгтэй хүүхдийн 4.9 хувь нь дунд хэлбэрийн тураалтай, харин эмэгтэй хүүхдийн 4.5 хувь нь дунд хэлбэрийн тураалтай байна.

Тав хүртэлх насны хүүхдийн 15.9 хувь нь дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой байна. Тав хүртэлх насны эрэгтэй хүүхдүүдийн өсөлтийн хоцрогдол эмэгтэй хүүхдүүдийнхээс дээгүүр байна.

“Хүүхэд хөгжил – 2000” судалгааны дүнгээр тав хүртэлх насны туранхай хүүхдийн 5.5 хувь нь дунд хэлбэрийн туранхай байсан бол 2010 онд 2.3 хувь болж буурсан байна. Тав хүртэлх насны туранхай эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 2005-2010 онд 0.6 пунктээр нэмэгдсэн бол эмэгтэй хүүхдийн эзлэх хувь 0.3 пунктээр буурсан байна.

² НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-аас зөвлөмж болгосон ДЭМБ/АНУ-ын Эрүүл мэндийн Статистикийн үндэсний төвийн боловсруулсан стандарт



Хүснэгт 5.

5 хүртэлх насны хүүхдүүдийн хоол тэжээлийн үзүүлэлт, дунд хэлбэрээр, 2000, 2005, 2010 он

Хоол тэжээлийн үзүүлэлт	Хүйс	2000	2005	2010
5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь	Улсын дундаж	12.7	6.3	4.7
	Эрэгтэй	12.7	5.9	4.9
	Эмэгтэй	12.7	6.6	4.5
5 хүртэлх насны өсөлт хоцрогдолтой (насанд нь өндрийг харьцуулахад) хүүхдийн эзлэх хувь	Улсын дундаж	24.6	20.9	15.9
	Эрэгтэй	25.4	21.5	17.5
	Эмэгтэй	23.8	20.3	14.2
5 хүртэлх насны туранхай (өндөрт нь жинг харьцуулахад) хүүхдийн эзлэх хувь	Улсын дундаж	5.5	2.2	2.3
	Эрэгтэй	5.6	1.9	2.5
	Эмэгтэй	5.5	2.4	2.1

V. Эрх мэдэл, шийдвэр гаргах

Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмших болсон боловч удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байна. Хэдийгээр Улсын их хурлын 1992 оны сонгуулиар эмэгтэйчүүд үндэсний парламентын нийт гишүүдийн 3.9 хувь, 1996 оны сонгуулиар 9.2 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувийн төлөөлөлтэй болж өсөх хандлагатай байсан ч 2004 оны сонгуулиар 6.6 хувь, 2008 оны сонгуулиар 3.9 хувь болж буурчээ.

Улсын Их хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 7.7 хувь, 1996 онд 9.3 хувь, 2004 онд 13.7 хувь, 2008 оны сонгуулиар 18.5 хувь болж тасралтгүй өссөн нь харагдаж байна.

Ажиллах хүчний 2010 оны судалгаагаар нийт 58.9 мянган хүн хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийн хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөлмөр эрхэлж буй нийт хүн амын 5.7 хувьтай тэнцэж байна. Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерийн хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын 37.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээгээр нийт 135.9 мянган мэргэжилтэн байгаагийн дийлэнх буюу 89.5 мянга нь эмэгтэйчүүд байна.



ДҮГНЭЛТ

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь хүн амын эрүүл мэндийн байдлын талаарх нэг гол үзүүлэлт билээ. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн төрөлтөөс тооцсон дундаж наслалтын ялгаа 2000 онд 5.7 жил байснаа 2011 онд 3.4 пунктээр нэмэгдэж, 9.1 жил болсон байна.

Сүүлийн жилүүдэд эрэгтэй, эмэгтэйчүүд орой гэрлэж байгаа нь нэг талаас зах зээлийн өнөөгийн нөхцөлд гэр бүл болох бэлтгэл, эдийн засгийн боломжоо хангах, сурч боловсрох зэрэг олон шалтгаанаас хамаарч байж болох ба нөгөө талаас залуучуудын үүрэг хариуцлага, ухамсар, амьдрах ухаанд өөрчлөлт гарсантай ч холбоотой байж болох талтай.

Хотын эмэгтэйчүүд нь хөдөөгийн эмэгтэйчүүдийг бодвол 2 насаар орой гэрлэж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 15-24 насны залуучуудын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.5 хувь байгаа нь 2000 оныхоос 0.8 пунктээр өссөний дотор эрэгтэйчүүдийнх 1.0 пункт, эмэгтэйчүүдийнх 0.5 пунктээр нэмэгджээ.

Боловсролын шат ахих тусам эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад өндөр байгааг харуулж байгаа боловч сүүлийн 11 жилийн байдлаар энэхүү харьцаа буурах хандлагатай байна.

Ажиллагчдыг салбараар ангилж үзвэл, хөдөө аж ахуй, худалдааны салбарт хүмүүс олноор ажиллах байгаа бөгөөд хүйсийн харьцаа ерөнхийдөө ойролцоо, харин зарим салбарт аль нэг хүйс нь зонхилж байна. Ажиллах хүчний 2010 оны судалгааны дүнгээс үзэхэд байр, орон сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд зонхилж байхад уул уурхайн олборлолт, цахилгаан, хий уур, агааржуулалтын хангамж, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын даатгалын салбарт эрэгтэйчүүд илүү зонхилж байна.

Нийт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн 46.8 хувь нь цалин хөлстэй ажиллагч байхад эрэгтэйчүүдийн 38.5 хувь нь цалин хөлстэй ажиллагч байна.

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхлэгчдийн дотор эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин ойролцоо байгаа ч 2011 оны байдлаар эмэгтэйчүүдийн сарын дундаж цалингийн түвшин эрэгтэйчүүдийн сарын дундаж цалингаас 18.9 орчим хувиар доогуур байна.

Эмэгтэйчүүд бөөний ба жижиглэн худалдаа, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, зочид буудал, зоогийн газар, санхүүгийн гүйлгээ зэрэг хөнгөн салбарт, харин эрэгтэйчүүд уул уурхай, барилга, зам тээвэр зэрэг өндөр бүтээмжтэй салбарт зонхилж байгаа нь тэдний цалин хөлсний түвшинд нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмших болсон боловч удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байна.



Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

ХАВСРАЛТ

АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 5 дугаар сарын 31-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2012 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлынхаас 1.9 хувиар* өсчээ¹.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхтай ижил түвшинд, өмнөх оны мөн үеийнхээс 2.3 хувиар өсчээ².

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний улиралд 149.8 тэрбум ам.долларын* алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 10.8 тэрбум ам.долл буюу 7.8 хувиар* өсчээ³.

Тус улсын Холбооны нөөцийн сан (Төв банк)-гийн урьдчилсан тооцоогоор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 1.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 5.2 хувиар өссөн байна⁴.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 5 дугаар сард 8.2 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 пунктээр өсчээ².

Япон улсын эдийн засаг

Япон улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны институтын урьдчилсан тооцоогоор (2012 оны 5 дугаар сарын 17-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлынхаас 1.0 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 4.1 хувиар өсчээ⁵.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 4 дүгээр сард 100.4 (2010=100) байгаа нь өмнөх сарынхаас 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.4 хувиар өсчээ⁶.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 4 сард урьдчилсан гүйцэтгэлээр 2065.2 тэрбум иений алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 1898.2 тэрбум иен буюу 12.4 дахин өсчээ⁷.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 4 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх сарынхаас 0.2 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 13.4 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 4 дүгээр сард 4.6 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 пунктээр өсчээ⁹.

Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг

Европын холбооны статистикийн байгууллагын урьдчилсан тооцоогоор (2012 оны 6 дугаар сарын 6-нд мэдээлснээр) тус холбооны гишүүн 27 орны зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлынхтай ижил түвшинд*, өмнөх оны мөн үеийнхээс 0.1 хувиар* өссөн байна.

Инфляцийн түвшин 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний улиралд 42.8 тэрбум еврогийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 10.8 тэрбум евро буюу 20.1 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 3 дугаар сард өмнөх сарынхаас 0.4 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 1.9 хувиар буурсан байна.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 4 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 10.3 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.8 пунктээр өсчээ⁹.

ОХУ-ын эдийн засаг

ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны урьдчилсан тооцоогоор (2012 оны 4 дүгээр сарын 25-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеийнхээс 4.0 хувиар өссөн байна¹⁰.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 хувиар нэмэгджээ.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний улиралд 60.5 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 12.3 тэрбум ам.долл буюу 25.5 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 5.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1.3 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 4 дүгээр сард 5.8 хувь болж, өмнөх сарынхаас 0.7 пунктээр буурсан байна¹¹.

* - Улирлын нөлөөллийг тооцсон



БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 4 дүгээр сарын 13-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлынхаас 1.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувиар өсчээ¹².

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний улиралд 10.2 сая ам.долларын алдагдалтай гарч байсан бол 2012 оны эхний улиралд 6.6 сая ам.долларын ашигтай гарчээ¹³.

Харин аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 2012 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувиар өсчээ¹⁴.

Зэсийн үнэ

Лондонгийн металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2011 оны 12 дугаар сард дунджаар 7567.55 ам.долл байсан бол 2012 оны 5 дугаар сард дунджаар 7919.93 ам.долл болж, 352.38 ам.долл буюу 4.7 хувиар өссөн байна. 1 тонн цэвэр зэсийн үнэ 2012 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 1007.12 ам.долл буюу 11.3 хувиар буурчээ¹⁴ /Зураг 1/.


Алтны үнэ

Лондонгийн металлын биржид 1 унц алтны үнэ 2011 оны 12 дугаар сард дунджаар 1652.31 ам.долл байсан бол 2012 оны 5 дугаар сард дунджаар 1585.50 ам.долл болж, 66.80 ам.долл буюу 4.0 хувиар буурсан байна. 1 унц алтны дундаж үнэ 2012 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 75.07 ам.долл буюу 5.0 хувиар өсчээ¹⁵ /Зураг 2/.

Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррел газрын тосны үнэ 2011 оны 12 дугаар сард дунджаар 98.21 ам.долл байсан бол 2012 оны 5 дугаар сард дунджаар 94.70 ам.долл болж, 3.51 ам.долл буюу 3.6 хувиар буурсан байна. 1 баррел газрын тосны дундаж үнэ 2012 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 6.70 ам.долл буюу 6.6 хувиар буурчээ¹⁶ /Зураг 3/.

Зураг-1



Зураг-2



Зураг-3



**Хөрөнгийн биржийн индекс**

АНУ-ын хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2012 оны 5 дугаар сард дунджаар 12721.08 нэгж болж, өмнөх сарынхаас 309.67 нэгж буюу 2.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 141.09 нэгж буюу 1.1 хувиар нэмэгджээ¹⁷.

Токиогийн хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2012 оны 5 дугаар сард дунджаар 8842.54 нэгж болж, өмнөх сарынхаас 784.88 нэгж буюу 8.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 808.24 нэгж буюу 8.4 хувиар буурчээ¹⁷.

Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2012 оны 5 дугаар сард дунджаар 5461.44 нэгж болж, өмнөх сарынхаас 264.14 нэгж буюу 4.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 476.53 нэгж буюу 8.0 хувиар буурчээ¹⁷.

Эх үүсвэр:

1. <http://bea.gov>
2. <http://stats.bls.gov>
3. <http://www.census.gov/foreign-trade>
4. <http://www.federalreserve.gov>
5. <http://www.esri.cao.go.jp>
6. <http://www.stat.go.jp>
7. <http://www.customs.go.jp>
8. <http://www.meti.go.jp>
9. <http://epp.eurostat.ec.europa.eu>
10. <http://www.economy.gov.ru>
11. <http://www.gks.ru>
12. <http://www.stats.gov.cn>
13. <http://www.mofcom.gov.cn>
14. <http://www.lme.com>
15. <http://www.lbma.org.uk>
16. <http://www.nymex.com>
17. <http://finance.yahoo.com>

ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ИНДЕКС, сараар.

нэгж

Он	Аж үйлдвэрийн Dow Jones ¹	Nikkei-225 ²	FTSE-100 ³
2011 I	11802.37	10449.53	5971.59
II	12190.00	10622.27	6020.97
III	12081.48	9852.45	5856.92
IV	12434.88	9644.63	6007.86
V	12579.99	9650.78	5937.97
VI	12097.31	9541.53	5792.17
VII	12512.33	9996.68	5909.81
VIII	11326.62	9072.94	5271.31
IX	11175.45	8695.42	5228.49
X	11515.93	8733.56	5408.62
XI	11804.33	8506.11	5402.51
XII	12075.68	8507.32	5480.09
2011 I-XII	11957.57	9429.30	5681.39
2012 I	12550.89	8616.71	5694.45
II	12889.05	9242.33	5893.35
III	13079.47	9962.35	5875.40
IV	13030.75	9627.42	5725.58
V	12721.08	8842.54	5461.44

Тайлбар:

1. АНУ-ын хөрөнгийн биржийн индекс
2. Токиогийн хөрөнгийн биржийн индекс
3. Лондонгийн хөрөнгийн биржийн индекс

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд хэвлэв.

Хаяг :

14200 Улаанбаатар, Монгол Улс
Засгийн Газрын III байр, Өрөө-113

<http://www.nso.mn>

E-mail: information@nso.mn,
nso@magicnet.mn

Факс: (976-11) 329271

Утас: (976-11) 322424, (976-11) 326414